

АГУУЛГА

ОРШИЛ 4

БҮЛЭГ 1. АГУУЛАХЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	5
1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО	5
1.3 АГУУЛАХЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
1.3.1 Агуулахын байршил, орчны тойм зураг	5
1.3.2 Агуулахын үндсэн байгууламж	6
1.4 АШИГЛАХ ХИМИЙН БОДИСЫН ТОО ХЭМЖЭЭ	11
1.5 ДЭД БҮТЭЦ	14
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14
2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	15
2.2 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
2.3 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
2.4 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
2.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	26
2.6.1 Дотоодын хяналт шинжилгээ.....	26
2.6.2 Хөндлөнгийн хяналт шинжилгээ	32
2.7 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	43
ДҮГНЭЛТ 44	

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1. Химийн бодисын нэр төрөл, CAS дугаар.....	11
Хүснэгт 2-1. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	14
Хүснэгт 2-2. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
Хүснэгт 2-3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	22
Хүснэгт 2-4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	24
Хүснэгт 2-5. Хэмжилт хийх үеийн цаг агаарын үзүүлэлтүүд	26
Хүснэгт 2-6. Дуу чимээний хэмжилтийн үзүүлэлт	26
Хүснэгт 2-7. Агаарын чанарын хэмжилт хийсэн байршил	27
Хүснэгт 2-8. Хөрсний дээж авсан цэгийн байршил	28
Хүснэгт 2-9. Хөрсний хими шинж чанар	30
Хүснэгт 2-10. Хөрсний механик бүрэлдэхүүн	30
Хүснэгт 2-11. Хөрсөн дэх хүнд металлуудын агууламж	31
Хүснэгт 2-12. Усны чанарын газар дээрх хэмжилтийн үр дүн.....	34
Хүснэгт 2-13. Уст цэгүүдийн физикийн үзүүлэлтүүд.....	34

Хүснэгт 2-14. Уст цэгүүдийн химийн үзүүлэлтүүд.....	34
Хүснэгт 2-15. Усан дахь хүнд металлын шинжилгээний үр дүн.....	35
Хүснэгт 2-16. Ургамлын бичиглэл хийсэн бланк.....	36
Хүснэгт 2-17. Браун-Бланкегийн баллын хэмжээс	36
Хүснэгт 2-18. Ургамлын зүйлийн бүрдлийн жагсаалт.....	37
Хүснэгт 2-19. Зонхилох амьтны зүйлийн жагсаалт	41
Хүснэгт 2-20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	43

Зургийн жагсаалт

Зураг 1-1. Агуулахын байршил.....	6
Зураг 1-2. Оффисын барилга	7
Зураг 1-3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх танхим.....	7
Зураг 1-4. Оффисын анхны тусламжийн хайрцаг, аюулгүй ажиллагааны самбар	8
Зураг 1-5. Ажилчдын гал тогоо, цайны газар	8
Зураг 1-6. Оффис доторх галын булан	9
Зураг 1-7. Ажилчдын хувцас солих өрөө	9
Зураг 1-8. Оффисын гадна байрлах цуглах цэг болон харуулын байр.....	9
Зураг 1-9. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа.....	10
Зураг 1-10. Химийн бодисын агуулахын агааржуулалт болон агааржуулалтын бүртгэлийн хуудас	10
Зураг 1-11. Химийн бодисын сав баглаа боодол	10
Зураг 2-1. Химийн бодисын агуулахын агааржуулалтын систем болон нүд угаагч	16
Зураг 2-2. Аюултай хог хаягдлын дагалдах бичиг.....	16
Зураг 2-4. Химийн бодисын асгаралтаас сэргийлсэн саармагжуулах иж бүрдэл	17
Зураг 2-4. Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээ хийгдсэн байдал	17
Зураг 2-6. Тээврийн хэрэгслийн зогсоолд хурдны хязгаарлалт анхааруулсан замын тэмдэг тэмдэглэгээ	18
Зураг 2-7. Усны хэрэглээг зөв зохистой хэрэглэх зөвлөмж самбар	18
Зураг 2-8. Хашааны гадна зам дагуу тарьсан мод.....	19
Зураг 2-8. Ногоон байгууламжийн үр дүн	20
Зураг 2-9. Химийн бодисын агуулахын орчин тойрон.....	21
Зураг 2-11. ХАБЭА зааварчилгаа өгөх өрөө	22
Зураг 2-11. ХАБЭА сургалтын сертификат.....	22
Зураг 2-13. Химийн бодисын агуулахын аюулгүйн санамжийн самбар.....	23
Зураг 2-14. Химийн бодисын агуулах болон оффист байрлах галын хорын хэрэгсэл, мэдээний самбар	23
Зураг 2-14. Хогийн цэгийн цэвэрлэгээ	24
Зураг 2-16. Сургалт явагдаж буй байдал	25
Зураг 2-16. АТОМТЕХ 6130 зөөврийн багаж	33
Зураг 2-17. Уст цэгт дээжлэлт хийж буй байдал	33
Зураг 2-18. Усны дээжлэлт хийсэн байршил болон дээжлэлт хийгдэж буй байдал	33

Зураг 2-19. Ургамлын бичиглэлийн үйл явц.....	36
Зураг 2-20. Juice package программ	37
Зураг 2-21. ArcGIS программ	37
Зураг 2-22. Төслийн талбайн ургамалжилтын зураг	39
Зураг 2-23. Төслийн талбай орчмын NDVI зураг.....	40
Зураг 2-24. Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлал	41
Зураг 2-25. ХАБЭА сүргалтын явц.....	43
Графикийн жагсаалт	
График 2-1. Дуу шуугианы хэмжилтийн дүн	27
График 2-2. Нийт тоосны хэмжилтийн дүн.....	28
График 2-3. Хөрсний агро-хими шинж чанар.....	29
График 2-4. Хөрсний механик бүрэлдэхүүн	31
График 2-5. Хөрсний хүнд металлын түвшин.....	32
График 2-6. Ургамлын амьдралын хэлбэр	38
График 2-7. Талбай дах ургамлын аж ахуйн бүлэг	38



Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах
Мэйжор дриллинг монгол ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ОРШИЛ

Мэйжор дриллинг монгол ХХК нь Хан-уул дүүргийн 3-р хороонд байрлах Химийн бодисын агуулахдаа 2024 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) – ний нэмэлт тодотгол тайланг байгаль орчны үнааэлгээ, зөвлөх үйлчилгээний Баялаг Эко ХХК-аар хийлгэж, 2024 оны 10 сарын 17-нд БОУАӨЯ-аар батлуулсан тул, тус БОННУ-ий БОМТ-г 2025 оны БОМТ-өөр боловсруулан батлуулна. Харин 2022 онд БОУАӨЯ-аар батлуулсан БОННУ-ий нэмэлт тодотголын хүрээнд 3 дахь жилийн БОМТ – ийн тайланг 2024 онд боловсруулан батлуулсан.

Тус 2024 оны БОМТ-нд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн энэхүү биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын 4.1-т заасны дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу боловсрууллаа.



Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах
Мэйжор дриллинг монгол ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

БҮЛЭГ 1. АГУУЛАХЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	Химийн бодисын агуулах
Төсөл хэрэгжүүлэгч:	Мэйжор Дриллинг Монгол ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019012091
Регистрийн дугаар:	2704358
Хаяг:	Улаанбаатар хот, 17061, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ажилчдын гудамж
Утас:	+976 70119950, +976 99111293
Цахим шуудан:	ulzi.chuluun@majordrilling.com


1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглах химийн бодисуудыг тусгай зөвшөөрөл бүхий ханган нийлүүлэгчээс худалдан авч, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах Шинэст ХК-ийн эзэмшлийн химийн бодисын агуулахыг түрээслэн түр хадгалан, цаашид Оюу Толгой ХХК болон бусад захиалагч компаниудын өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулахад химийн бодисуудыг хэрэглэнэ.

1.3 АГУУЛАХЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.3.1 Агуулахын байршил, орчны тойм зураг

Мэйжор дриллинг монгол ХХК-ийн Химийн бодисын агуулах нь Хан-Уул дүүргийн 3-р хороонд үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд нийт 13,044 м³ (1.3 га) талбайд үйлд ажиллагаагаа явуулж байна. Агуулахын байршлыг Зураг 1-1-т тусгав.



Зураг 1-1. Агуулахын байршил

Мэйжор дриллинг монгол ХХК-ийн барилга нь үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд төслийн барилгын хойд талд Витафит үйлдвэр, урд талд Гоё тараг үйлдвэр, замын эсрэг талд Дулааны 3-р цахилгаан станц, УБЦТС-ын баруун түгээх төв тус тус байрлана.

1.3.2 Агуулахын үндсэн байгууламж

Төслийн талбай нь оффисын барилга болон засварын цех, химийн бодисын агуулах гэсэн үндсэн 3 байгууламжаас бүрдэнэ.

1. Оффис. Оффисын барилга дотор аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг өрөө, ажилчдын гал тогоо, цайны газар, хувцас солих өрөө зэрэг байна.



Зураг 1-2. Оффисын барилга

Оффист химийн бодисын агуулахад ажиллах ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгнө.



Зураг 1-3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх танхим

- **Оффисын аюулгүй ажиллагааны самбар**

Оффисын анхны тусламжийн хайрцаг, аюулгүй ажиллагааны самбарыг Зураг 1-4-т харуулав.



Зураг 1-4. Оффисын анхны тусламжийн хайрцаг, аюулгүй ажиллагааны самбар

- **Ажилчдын цайны газар**

Оффис доторх ажилчдын цайны газар болон гал тогоог Зураг 1-5–т харуулав.



Зураг 1-5. Ажилчдын гал тогоо, цайны газар

- **Оффисын галын аюулгүй ажиллагааны мэдээллийн булан**

Оффисын аваарын гарцын схем зураг, галын самбар, галын мэдээллийн булан зургийг Зураг 1-6–т харуулав.





Зураг 1-6. Оффис доторх галын булан

- **Ажилчдын хувцас солих өрөө**

Ажилчдын хувцас солих өрөөг Зураг 1-7–т харуулав.



Зураг 1-7. Ажилчдын хувцас солих өрөө

Оффисын гадна байрлах цуглах цэг болон харуулын байрыг Зураг 1-8–т харуулав.



Зураг 1-8. Оффисын гадна байрлах цуглах цэг болон харуулын байр

2. Химийн бодисын агуулах. Химийн бодисын агуулахын барилга нь 34.2м² талбайтай, цэвэр бохир ус, дулаан нь төвийн нэгдсэн шугамд холбогдсон, механик агааржуулалттай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, хана, шал нь химийн бодисоос үүссэн тоос, уур манан тогтохооргүй гөлгөр гадаргуутай, анхааруулах тэмдэг, дохио үг, санамж болон шаардлагатай үед холбоо барих утасны жагсаалтыг ил байршуулсан байна.

Химийн бодисын агуулах руу орох хэсэгт байрлах аюулгүй ажиллагааны зааварчилгааг Зураг 1-9–т харуулав.



Зураг 1-9. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Төсөл хэрэгжүүлэгчийн химийн бодисын агуулахын тавиур, бодисын сав баглаа боодол нь Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд (Монгол улсын шадар сайд, байгаль орчин, аялал жуулчлалын сайд, эрүүл мэндийн сайдын 2017оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт) заасан химийн бодисын тавиур нь доорх шаардлагыг хангаж байна. Тухайлбал:

- Химийн бодисын тавиур нь шатамхай биш, химийн бодист тэсвэртэй, бат бөх материалаар хийгдсэн, тогтвортой хөдөлгөөнгүй суурилагдсан
- Тавиур дээр хураасан бодис гулсаж унахаас хамгаалсан хаалттай
- Тавиур нь хэт өргөн биш, хураасан бодис нүдэнд ил харагдахаар, хүрч болохуйц өргөнтэй байна.

Химийн бодисын агуулахын агааржуулалтыг болон бүртгэлийн хуудсыг Зураг 1-10–г харуулав.



Зураг 1-10. Химийн бодисын агуулахын агааржуулалт болон агааржуулалтын бүртгэлийн хуудас



Зураг 1-11. Химийн бодисын сав баглаа боодол

1.4 АШИГЛАХ ХИМИЙН БОДИСЫН ТОО ХЭМЖЭЭ

Мэйжор дриллинг монгол ХХК нь олон тооны захиалагч компаниудын хэрэгцээ, шаардлага, стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэн зэс, алт, нүүрс, уран, поташ болон усны өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэх бөгөөд алмазан, чиглэлт, урвуу эргэлтэт, усны болон далд уурхайн өрөмдлөг зэрэг 28 өрмийн машинтайгаар өрөмдлөгийн үйлчилгээг гүйцэтгэдэг байна. Өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглах хуучин 62 химийн бодис дээр нэмэгдэж буй 16 буюу нийт 78 химийн бодисын нэршил, CAS дугаар, химийн томьёо, ашиглах тоо хэмжээг Хүснэгт 1-1-т тусгав.

Хүснэгт 1-1. Химийн бодисын нэр төрөл, CAS дугаар

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томьёо	CAS дугаар	Хэмжээ, жилд
1.	Өрмийн алхны тос	Hammer oil 150	Highly refined paraffinnic oil >60%	5500-88	1000 л
2.		Hammer oil 320			1000 л
3.	Өрмийн штангийн тос	Amc liquid rod grease	/CH ₂ -O-C(O)-R ₁ /CH-O-C(O)-R ₂ /CH ₂ -O-C(O)-R ₃ /-	7641-44	2000 л
4.	Өрмийн штангийн тос /өндөр идэвхт/	Amc rod grease xtra tacky	Barium, acetate tallow fatty acid complex hydrocarbon mineral oil (70-80%)	64742-52-5	4000 кг
5.	Өрмийн хошууны тос	Ep bit lube		6921-10-3	4000 л
6.	Ургамлын гаралтай тастагчийн тос	Amc universal		7639-46	5000 л
7.	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	Penetrol xtra	Refined Vegetable oil /CH ₂ -O-C(O)-R ₁ /CH-O-C(O)-R ₂ /CH ₂ -O-C(O)-R ₃ /-	7639-46	800 л
8.	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	Torque-free xtra		7177-11	800 л
9.	Органик полимер	Austrol	[C ₆ H ₇ O ₂ (OH) ₃ -X(OC ₂ H ₅)X] _n 100% ethylcellulose	9004-57-3	15 тн
10.	Шингэн полимер	AMC-liquid pol	Drilling fluid additive	60815	15 тн
11.	Сэргээх полимер	AMC-CR-650	Drilling fluid additive, 100%	4902-92	45 тн
12.	Полимер, өсдөг	AMC-AUS PLUG	Cross-linked polyacrylamide, 100%	9003-05-8	2000 кг
13.	Нийлэг ко-	AUS-floc	Co-Polymer	4902-93	800 л
14.	полимер	AUS-floc blocks		6089-06	768 кг
15.	Цэвэрлэгч полимер	Well clean	Sodium carboxymethyl cellulose, 100%	7758-16-9	480 кг
16.	Полимер, цавуулаг	AMC PAC-L	Sodium carboxymethyl cellulose, 100%	9004-32-4	15 тн
17.		AMC PAC-R			100 тн
18.		EZEE PAC-R			100 тн
19.	Өрөмдлөгийн цемент	GYP-SET 15	Calcium sulfate hemihydrate	10034-76-1	2000 кг
20.		GYP-SET 30			2000 кг
21.	Шингэн цемент	FR-100L	Naphthalenesulfonic acids	68153-01-5	800 л
22.	Цементийн нэмэлт	AMC XXX 10	Calcium chloride 80%	10043-52-4	320 кг
23.		AMC XXX 15	fly ash-low quartz 20%	68131-74-8	480 кг
24.	Өрөмдлөгийн хөөс	Super foam	Anionic surfactants, 60%	7177-08	800 л
25.	Өрөмдлөгийн нийлэг хөөс	AUS GRIP A Eco	Polyethylene/polypropylene/glycol glyceryl ether	9082-00-2	548.1 кг
26.		AUS GRIP B Eco	Polymeric diphenylmethane diisocyanate	9016-87-9	81.9 кг

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томьёо	CAS дугаар	Хэмжээ, жилд
27.	Өрөмдлөгийн тэнцвэржүүлэгч	AMC ground stabilizer	Vinyl acetate homopolymer 30-60%	9003-20-7	800 л
28.	Өрөмдлөгийн хагарал тогтоогч	Fracseal	Micronised organic cellulose fiber, 100%	9004-34-6	875 л
29.	Өрмийн угаалгын шингэн	AMC Truck	Detergent blend, 100 %	7639-45	800 л
30.	Концентратат цэвэрлэгч бодис	AUS DET XTRA	Nonhazardous ingredients, 60	7732-18-5	800 л
31.	Ус ангижруулагч	Soda ash	Sodium carbonate, 99%	497-19-8	1000 кг
32.	Кальцийн хлорид	Calcium chloride	Calcium chloride, 85%	10043-52-4	1000 кг
33.	Газрын давс	Potassium chloride	Potassium chloride, 99% KCL	7447-40-7	10 тн
34.	Өрөмдлөгийн ус ангижруулагч	AMC water conditioner	EDTA tetrasodium salt 75%, sodium carbonate 25%	64-02-8 497-19-8	480 кг
35.	Барийн сульфат	Barite	Barium sulfate	7727-43-7	1200 кг
36.	Ус алдалт тогтоогч	Shur seal	Shredded paper	42071	200 кг
37.	Филтрекс	Filtrex	Ingredients determined to be hazardous>90	9003-20-7	2000 кг
38.	Өрмийн шингэн найруулагч	Ausgel	N/A	N/A	2000 кг
39.	Супер Поли Өрөмдлөгийн полимер	Super Poly	C8H14Cl2N2O2 Акрилаци кополимер 30-40%, хөнгөн нефтийн нэрмэл бодис 10-30%, ус 30-70%	N/A	2 тн
40.	Өрмийн шавар	Super Gel	Bentonite (organic clay) 60-100%	1302-78-9	2 тн
41.	Өрмийн товуд	Rod Grease	-	9003-29-6	2 тн
42.	ПЛАГ	Plug	-	9003-004-7	2 тн
43.	Өрмийн тос /усан суурьт дрилл люб/	Drill Lube	(C6H10O5)n	91050-89-4	2 тн
44.	Целлюлоз	CX-Troll	Polysachharide 60-100%	9004-34-6	2 тн
45.	Анионик полимер	CHP Plus	(C7H12O2C5H8O2*C4H6O2)x Акрилет кополимер 90-95%	25035-69-2	2 тн
46.	Ургамлын гаралтай уусдаг тос	Super Lube	Triethanolamine <1, sodium sulfate <5	N/A	50 тн
47.	Тос	AMC Thread Grease-DRTG	N/A	N/A	5 тн
48.	Ксантан хүнсний өтгөрүүлэгч	Sino mud Poly XCD	Ксантан бохь 60-90%	11138-66-2	3 тн
49.	Биоцид	AMC Biocide G	Tetrakis (hydroxymethyl) phos [Honiumsulfate <25, ingredients determined not to be hazardous >60	55566-30-08	3 тн
50.	Усан суурьтай өрөмдлөгийн шингэнд хэрэглэх зориулалттай силикон суурьтай бүх төрлийн хөөс арилгагч	AUS Defoamer G	N/A	26-5533	3 тн

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томьёо	CAS дугаар	Хэмжээ, жилд
51.	Цардуул	AMC Aus Dex	Холимог >60	9005-25-8	3 тн
52.	Органик полимер	AMC Ezee troll	Sodium carboxymethyl cellulose (>60%); sodium carbonate (<5%)	N/A	100 тн
53.	Нимбэгийн хүчил	Citric Acid	Citric acid > -96	77-92-9	3 тн
54.	Өндөр чанарын занарын урвал саармагжуулах	Sinomud Kla-stab	Полиамин	9046-10-0	3 тн
55.	Өрөмдлөгийн шингэний нэгдэл	AMC Ben Viscosifier,	Bentonite, >94 %	1302-78-9	3 тн
56.	Өрөмдлөгийн шингэн нэмэлт	AMC Glute 9 AMC Glute 50	Глутральдегид 50%, ус 50%	111-30-8 7732-18-5	3 тн
57.	Натрийн сульфит	Sodium Sulphite Sodium Sulfate Anhydrous	Sodium Sulphite >95	7757-83-7	3 тн
58.	Өрөмдлөгийн нэмэлт шингэн	AMC Quick Seal	Найрлагыг аюулгүй гэж тодорхойлсон, 100%	62-2620	3 тн
59.	Сийл лац	Sinomud Seal	Шааран ноосон эслэг 60-100 %	65996-69-2	3 тн
60.	Натрийн бикарбонат	AMC Sodium Bicarbonate	Sodium bicarbonate >99	144-55-5	3 тн
61.	Цемент түргэн хатаагч, үсгүйжүүлэгч нэмэлт	BASF MasterRheobuild 1000NT	Calcium naphthalene sulphonate-formaldehyde condensate (25-50%)	37293-74-6	3 тн
62.	Магнийн оксид	Magnesium Oxide	Магнийн оксид >65 %, кальцийн оксид 1-3 % үлдсэн аюулгүй найрлага	N/A	3 тн
Шинээр нэмэгдэж буй химийн бодисууд					
63.	Натрийн асфальт сульфонат	SAS-Shale Inhibitor	Холимог	-	1.5 тн
64.	Кальцийн гидроксид	Hydrated lime	Ca(OH) ₂	1305-62-0	10 тн
65.	Хувиргасан цардуул	CMS HT	Холимог	Холимог	20 тн
66.	Натрийн карбонат	Caustic Soda	Na ₂ CO ₃	497-19-8	90 тн
67.	Кальцийн карбонат	Calcium carbonate	CaCO ₃	13397-26-7 7732-18-5	80 тн
68.	Цементийн нэмэлт	Halad® 344 cement additive	N/A	N/A	1 тн
69.	Өрөмдлөгийн шаврын нэмэлт	SAS	N/A	14808-60-7	1.5 тн
70.	Эфирт суурилсан тосолгооны материал	Ester Based Lubricant CF	N/A	106168-45-0	5 тн
71.	Полиуретан шахах зуурмаг	AMC hydro EZ grout	-	-	5 тн
72.	Цемент, зуурмагийн нэмэлт	AMC hard set	-	-	5 тн

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томьёо	CAS дугаар	Хэмжээ, жилд
73.	Цооногийн эргэлт, шингэний алдагдлыг багасгана	AMC BOS FIX	<5% $Al_2(SO_4)_3$ >60% Полимер	10043-01-3	5 тн
74.	Целлюлоз	VIS	-	9004-34-6	20 тн
75.	Анионик полимер	AUS-FLOC L	-	9003-05-8	5 тн
76.	Өрмийн угаалгын шингэн	AMC Maxi Wash	Detergent blend, 100 %		800 л
77.	Цооног тогтворжуулагч	AMC Corewell	-	9003-05-8	5 тн
78.	Өрмийн шавар	CX Ben	Bentonite (organic clay) 60-100%	1302-78-9	10 тн

1.5 ДЭД БҮТЭЦ

Цахилгаан, дулаан, усан хангамж. Мэйжор дриллинг монгол ХХК-ийн химийн бодисын агуулах төслийн барилгын дулаан хангамж нь Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, цахилгаан хангамж нь Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-тай холбогдсон бөгөөд усан хангамжийн хувьд төвийн шугамд бүрэн холбогдсон байна.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан байдаг.

Нөгөө талаас төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

Мэйжор дриллинг монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын 2024 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 10,851,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 2-1. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал (төг)
1.	Байгаль орчныг хамгаалах	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,060,000
2.	Төлөвлөгөө	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	4,000,000



Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах
Мэйжор дриллинг монгол ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

3.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,605,000
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,420,000
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2,000,000
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 766,000
Нийт зардал		10,851,000

2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Химийн бодисын агуулахын төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрээр буюу агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усан орчин, ургамлан нөмрөгт тодорхойлж нийт 8 сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2024 оны БОМТ -д тусгасан бөгөөд биелэлтийг Хүснэгт 2-2-т тусгав.

Хүснэгт 2-2. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор авагдсан арга хэмжээний биелэлт, тайлбар
Агаарын чанар			
1.	Агуулахын дотоод агаарын чанар муудах	Агуулахын агааржуулалтын системийг шалгаж хяналтын хуудас бөглөх, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд тухай бүрт засварлах	Төслийн үйл ажиллагааны хугацаанд агуулахын агааржуулалтын системд ямар нэгэн эвдрэл гэмтэл гараагүй бөгөөд байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөл осол эрсдэл гараагүй байна. 
2.	Болзошгүй асагарлт, ослын үед химийн бодис ууршиж агаарт тархах	Химийн бодисын хаягдал, үлдэгдлийг тусад нь цуглуулж, Цэцүүх трейд ХХК-р устгуулах	Мэйжор дриллинг монгол ХХК нь химийн бодисын хаягдал үлдэгдлийг тусад нь цуглуулдаг бөгөөд 2024.05.30-ны Ш-24/049 дугаарт гэрээний дагуу Цэцүүх трейд ХХК-д аюултай хог хаягдлыг хүлээлгэн агч устгуулдаг (Хавсралт 6-1). 
3.	Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу хадгалаагүйн улмаас тухайн бодис шинж чанараа алдах	Тухайн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцлийг агуулахад бүрдүүлэх	Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр Химийн бодисын агуулах нь MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага хангаж байна гэж үзсэн байна.

Зураг 2-1. Химийн бодисын агуулахын агааржуулалтын систем болон нүд угаагч

Зураг 2-2. Аюултай хог хаягдлын дагалдах бичиг

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор авагдсан арга хэмжээний биелэлт, тайлбар
Хөрсөн бүрхэвч			
4.	Хөрсний бохирдол үүсэх	Болзошгүй байдлаар химийн бодис алдагдсан тохиолдолд хэрэглэх саармагжуулах иж бүрдлийн хэрэгслийг нэмж байрлуулах	Химийн бодисын агуулахад асгаралтаас сэргийлэх хэрэгсэл байршуулсан бөгөөд 2024 онд аюулгүй ажиллагаа алдагдсан осол эрсдэл гараагүй байна.  Зураг 2-3. Химийн бодисын асгаралтаас сэргийлсэн саармагжуулах иж бүрдэл
5.	Хөрс хог хаягдлаар бохирдох	Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	“Шарилжгүй Эрүүл Дүүрэг” аяны хүрээнд зохион байгуулагдаж буй хөл газрын ургамлыг цэвэрлэх ажлын хүрээнд орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын шарилж, хог хаягдлыг 2024 оны 07-р сарын 04-ий өдөр цэвэрлэсэн (Хавсралт 8).  Зураг 2-4. Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээ хийгдсэн байдал


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор авагдсан арга хэмжээний биелэлт, тайлбар
6.	Хөрс талхлагдах	Хашааны тээврийн хэрэгслийн зогсоолд хурдны хязгаарлалт болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Харуулын хашааны дэргэд болон оффисын авто зогсоолын дэргэд хурд хэтрүүлэхийг хориглосон тэмдэг болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байна.  Зураг 2-5. Тээврийн хэрэгслийн зогсоолд хурдны хязгаарлалт анхааруулсан замын тэмдэг
Усан орчин			
7.	Химийн бодис буруу хадгалалтаас үүдэн химийн бодис их хэмжээгээр алдагдсан тохиолдол гүний усыг бохирдуулж болзошгүй.	Химийн бодис, материалын хадгалалтын нөхцөлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах. Химийн бодис их хэмжээгээр алдагдсан тохиолдолд авах шүүрхай арга хэмжээний төлөвлөгөө шинэчлэн боловсруулах	Оффисын барилга доторх ариун цэврийн нойл болон гал тогоонд усыг хэмнэх талаар зөвлөмж самбар байршуулсан байна.  Зураг 2-6. Усны хэрэглээг зөв зохистой хэрэглэх зөвлөмж самбар Химийн бодисын агуулахад асгаралтаас сэргийлэх хэрэгсэл байршуулсан бөгөөд 2024 онд аюулгүй ажиллагаа алдагдсан осол эрсдэл гараагүй байна.
Ургамлан нөмрөг			

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор авагдсан арга хэмжээний биелэлт, тайлбар
8.	Ногоон байгууламжийн ургалт муудах	Агуулахын хашааны гадна талд тарьсан модыг усалж, арчилгаа тордлогоо хийх	Мэйжор дриллинг монгол ХХК-ийн хашааны гаднах зам дагуу 2022 онд тарьсан модыг арчилгаа тордлогоог тогтмол одоог хүртэл хийсээр байна.  Зураг 2-7. Хашааны гадна зам дагуу тарьсан мод

2.2 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын төслийн БОННУ тайланд төслийн талбайн 10 хувиас багагүй талбайд мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар ногоон байгууламжийг байгуулах ажлыг хийж гүйцэтгэхийг тусгасан байна.

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь үйл ажиллагаагаа явуулж эхэлснээсээ хойш төслийн талбайд болон төслийн талбайн гадна буюу авто замын хажууд мод бутлаг ургамал тарьж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 450ш гаруй моддыг тарьж ургуулаад байна. Төслийн талбай бүрэн цэцэрлэгжсэн тул 2024 онд нийгмийн харьцуулгын хүрээнд орон нутагтай хамтран Хан-уул дүүргийн 14 хорооны байрны гадаа болон Морингийн даваанд 15 мод тарьсан.



Зураг 2-8. Ногоон байгууламжийн үр дүн



Зураг 2-9. Химийн бодисын агуулахын орчин тойрон

2.3 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд түүх, соёлын өвд нөлөөлөл байхгүй учир хамгаалах арга хэмжээг төлөвлөөгүй байна.

2.4 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мэйжор дриллинг монгол ХХК нь осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2023-2024 оны хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Химийн бодисын агуулах болон оффис тус бүрд галын булантай бөгөөд галын иж бүрдлийг байрлуулсан
- Ажилчдад улирал бүр тогтмол галаас хамгаалах, гал гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж, шалгалт авч чадавхыг бэхжүүлдэг бөгөөд сургалтад хамрагдсан ажилтан бүр гэрчилгээ авдаг. Мөн химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.
- МКЛ сургалтын төвтэй хамтарч химийн бодис аюулгүй ажиллагаа сургалтыг тогтмол зохион байгуулсан бөгөөд 100 гаруй ажилтан хамруулсан байна.
- Агуулахад химийн бодис асгарах үед саармагжуулах хэрэгслийн иж бүрдлийг байрлуулсан.

Мэйжор дриллинг монгол ХХК нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу 2024 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 1,605,000 ₮ зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 2-3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзоошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
---	--	---	---------------------------------------

Мэйжор дриллинг монгол ХХК нь ажилчдадаа ХАБЭА зааварчилгаа өгдөг тусгай өрөөтэй бөгөөд МКЛ сургалтын төвтэй хамтарч химийн бодис аюулгүй ажиллагаа сургалтыг тогтмол зохион байгуулсаар байна.

1.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх зааварчилгааг үргэлжлүүлэн мөрдүүлж ажиллах



Зураг 2-10. ХАБЭА зааварчилгаа өгөх өрөө

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа алдагдах

Оффисын болон талбайн ажилчдыг ХАБЭА сургалтад тогтмол хамруулдаг бөгөөд хамрагдсан ажилтнууд тус бүрд сертификат олгодог (хавсралт-5).

2.

Ажилчдыг үргэлжлүүлэн ХАБЭА сургалтад хамруулах



Зураг 2-11. ХАБЭА сургалтын сертификат

№	Болзоошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
3.	Агуулахад аюулгүйн санамжийн самбар нэмж байрлуулах		Химийн бодисын агуулахын аюулгүйн санамжийн мэдээллийг химийн бодисын агуулахад байршуулсан.  Зураг 2-12. Химийн бодисын агуулахын аюулгүйн санамжийн самбар
4.	Гал түймэр	Галын хорыг цэнэглэж, ажиллагааг хангах	   Зураг 2-13. Химийн бодисын агуулах болон оффист байрлах галын хорын хэрэгсэл, мэдээний самбар Химийн бодисын агуулах болон оффис түс бүрд галын булантай бөгөөд галын иж бүрдлүүд, утаа мэдрэгч, дулаан мэдрэгч зэрэг байрлагдсан. Ажилчдад улирал бүр тогтмол галаас хамгаалах, гал гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж, шалгалт авч чадавхыг бэхжүүлдэг бөгөөд сургалтад хамрагдсан ажилтан бүр гэрчилгээ авдаг байна.

2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь 2023-2024 оны хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай 2023.10.18 өдөр №23/144 тоот Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээтэй бөгөөд гэрээний дагуу сар бүр тээвэрлүүлдэг.
- Аюултай хог хаягдлыг Цэцүүх Трейд ХХК-тай 2024.03.30 өдөр байгуулсан Т-24/049 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх болон, тээвэрлэлтийн гэрээтэй. Гэрээний дагуу химийн бодисын хаягдлыг 2024.10.24 өдөр № 000775 дагалдах бичгээр хүлээлгэн өгч, үстгүүлсэн байна.

Хүснэгт 2-4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
1.		Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад үргэлжлүүлэн тээвэрлүүлэх, актаар хүлээлгэж өгөх	Химийн бодисын агуулахын төслийн үйл ажиллагаанаас ахуйн хог хаягдал гарахгүй бөгөөд зөвхөн оффисын ажилчдын ахуйн хог хаягдал гардаг. Мэйжор Дриллинг Монгол ХХК нь оффисын ахуйн хог хаягдлыг газар дээр нь ангилан ялган савласан хогийн саванд хийдэг бөгөөд түүнийг ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ тээвэрлүүлдэг байна (Хавсралт 6).
	Ахуйн		Хогийн цэгийг цэвэрлэх үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн.
2.		Хогийн савыг арчиж цэвэрлэх	

Зураг 2-14. Хогийн цэгийн цэвэрлэгээ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
3.		Хогийн менежмент сургалт мэргэжлийн байгууллагаар ажилчдад орох	Ажилчдыг энгийн болон аюултай хог хаягдлын талаарх сургалтад 2024 оны 2 сард хамруулсан. 
4.	Аюултай	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг Цэцүүх трейд ХХК- р үргэлжлүүлэн тээвэрлүүлж, устгуулах	Цэцүүх Трейд ХХК-тай 2024.03.30 өдөр байгуулсан Т-24/049 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх болон, тээвэрлэлтийн гэрээний дагуу үргэлжлүүлэн химийн бодисын сав, баглаа боодлыг тээвэрлүүлж, устгуулж байна (Хавсралт-1-2).

Зураг 2-15. Сургалт явагдаж буй байдал

2.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь 2024 оны БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр буюу Мэйжор Дриллинг Монгол ХХК нь химийн бодисын агуулахын үйл ажиллагаанаас бий болж буй үр дагавруудыг хянах, илрүүлэх зорилгоор химийн бодисын агуулахын талбайд агаар, усны шинжилгээг жилд 1 удаа хийх харин хөрсний шинжилгээг жилд 2 удаа хийх
- Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1 удаа хийлгэх, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулах, дүгнэх

2.6.1 Дотоодын хяналт шинжилгээ

2.6.1.1 Агаарын чанар.

Агаарын чанарын хяналт мониторингийн хэмжилт хийх үед салхигүй, тогтуун байсан ба салхины хурд 0.4 – 0.6 м/с, температур 7.4 – 7.5 °C, агаарын чийгшил 22.4 – 25% байсан.

Хүснэгт 2-5. Хэмжилт хийх үеийн цаг агаарын үзүүлэлтүүд

Давтамж	Огноо	Температур	Чийг	Салхины хурд	Хэмжилтийн үйл явц
Хэмжилт – 1 (Ногоон байгууламжийн хашаанд)		7.4 °C	25 %	0.6 м/с	
	2024.10.18				
Хэмжилт – 2 (Агуулахын үүдэнд)		7.5 °C	22.4 %	0.4 м/с	

Дуу чимээний хэмжилтийг EXTECH Noise Dosimeter SL355 маркийн дуу чимээний хэмжигч багаж ашиглан тодорхойлсон.

Хүснэгт 2-6. Дуу чимээний хэмжилтийн үзүүлэлт

Хэмжилт	Дуу чимээ (дБА)	Хэмжилтийн үйл явц
Хэмжилт – 1 (Ногоон байгууламжийн хашаанд)	52	
Хэмжилт – 2 (Агуулахын үүдэнд)	44	
MNS 4585:2016 (дБА, 16 цагийн дундаж)		60

Төслийн талбайд хэмжсэн дуу чимээний үзүүлэлт нь MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын дуу шуугианы өдрийн цаг (07-22 цаг) буюу 16 цагийн дундаж хүлцэх агууламж 60 дБА-ийн хэмжээнд буюу давсан үзүүлэлт илрээгүй байна.




График 2-1. Дуу шуугианы хэмжилтийн дүн

Төслийн талбайд нийт, том болон нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжилтийг 2024.10.18-ны өдөр DustTrak DRX 8533 зөөврийн багажийн тусламжтайгаар хийж гүйцэтгэв. Төслийн талбайд агаарт агуулагдах TSP, PM_{2.5} болон PM₁₀ тоосонцрыг 2 давтамжтайгаар хэмжив. Хэмжилт хийсэн цэгийн газарзүйн солбицлыг доорх хүснэгтэд тусгав.

Хүснэгт 2-7. Агаарын чанарын хэмжилт хийсэн байршил

Давтамж	Газарзүйн солбицол		Хэмжих нэгж	PM _{2.5}	PM ₁₀	TSP	Хэмжилтийн үйл явц
	Өргөрөг	Уртраг					
Хэмжилт – 1 (оффисын үүднээс)	47°53'49.02''	106°52'24.31''	мкг/м ³	105	166	249	 
Хэмжилт – 2 (Агуулахын үүдэнд)	47°53'49.24''	106°52'22.87''		84	128	198	 
MNS: 4585:2016				-	-	500	

Төслийн агуулахын үүднээс болон оффисын урд хэсгээс хэмжилт авсан бөгөөд PM_{2.5}, PM₁₀, нийт тоосонцрын хэмжилтийн дүн MNS:4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартад заасан хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтгүй байна. Хэмжилтийн дүнг доорх графикт үзүүлэв.




График 2-2. Нийт тоосны хэмжилтийн дүн

2.6.1.2 Хөрсөн бүрхэвч.

Багаж хэрэгсэл: Хөрсний талбайн судалгаанд хүрз, метр, дээжийн уут, дээжийн хутгуур, фото аппарат, GPS, 10%-ийн давсны хүчлийн уусмал зэрэг багаж хэрэгсэл ашигласан.

Хөрсний хээрийн судалгааны явцад түс төслийн талбай доторх гадаргын төлөв, хөрсний хэв шинж, хөрсний хими, механик бүрэлдэхүүн зэргийг тодорхойлох болон хөрсөн дэх хүнд метал, бохирдлыг тодорхойлох зорилгоор 2 цэгт 0-15;30 см хүртэлх гүний хөрсний зүсэлт хийж нийт 3 ширхэг хөрсний дээж аван, бичиглэл хийж фото зургаар баримтжуулсан. Хөрсний хээрийн судалгааны цэгүүдийг сонгохдоо төслийн талбайн хөрсний хэв шинж болон хөрсний эвдрэл, талхагдлын түвшин зэргийг үндэслэн харьцуулах боломжит цэгүүдийг сонгож авав. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1991” стандартыг баримталсан. Дээж авсан цэгүүд нь ямар нэгэн хүний үйл ажиллагааны нөлөөтэй эвдрэл талхагдал багатай, ердийн хөрсөн бүрхэвчтэй байна. Хөрсний дээж авсан цэгийн координатыг Хүснэгт 2-8-т тусгав.

Хүснэгт 2-8. Хөрсний дээж авсан цэгийн байршил

№	Газарзүйн солбицол		Хэмжилтийн үйл явц
	Өргөрөг	Уртраг	
Агуулахын урд	47°53'48.88" N	106°52.2'23.27" E	
Зогсоолын баруун талд	47°53'48.37" N	106°52.24.64" E	

Лабораторийн задлан шинжилгээ: Төслийн талбайгаас авсан хөрсний дээжийн хими, физик шинж чанарын ерөнхий үзүүлэлтүүдийг “Газарзүй Геоэкологийн хүрээлэн” Хөрс-судлалын лабораторид доорх аргаар тодорхойлов.

Хөрсний үржил шимийн түвшнийг тодорхойлдог голлох үзүүлэлт болох хөрсний ялзмаг, хөдөлгөөнт фосфор, кали болон хөрсний хими шинж чанарын үзүүлэлт болох хөрсний урвалын орчин (pH), карбонатын агууламж, хөрсний хялбар уусах давсжилт (EC) гэсэн үзүүлэлтүүдийг

тодорхойлсон бөгөөд үзүүлэлт тус бүрийн үр дүнгийн талаар доор дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Хөрсний урвалын орчин (pH): Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг. Ерөнхийдөө хөрсний урвалын орчин дунд зэрэг хүчиллэгээс дунд зэрэг шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиромжтой гэж үздэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний урвалын орчин 8.63-8.75 хооронд буюу хүчтэй шүлтлэг орчинтой байгаа нь ургамал ургахад тохиромжгүй байна.

Хөрсний карбонатжилт: Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO_3)-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Хөрсөнд янз бүрийн анхдагч болон хоёрдогч карбонатууд байдаг. Эдгээрээс Хамгийн түгээмэл хэлбэр нь кальцид (CaCO_3) болон доломит [$\text{CaMg}(\text{CO}_3)_2$] юм. Карбонат нь хөрсний pH-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсийг карбонатын агууламжаар нь 0% карбонатжаагүй, 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж үнэлдэг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиромжтой гэж үзнэ. Судалгааны үр дүнгээс харахад карбонатгүй байна.




График 2-3. Хөрсний агро-хими шинж чанар

Хөрсний ялзмагийн агууламж: Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний ялзмагийн агууламж үе

давхаргуудад 2.013-3.989% буюу дунд зэрэг байгаа нь үржил шимээр дунд зэрэг байгааг илтгэж байна.

Хүснэгт 2-9. Хөрсний хими шинж чанар

№	Дээжийн дугаар	Гүн см	pH _{H2O} 1:5	CaCO ₃ %	Ялзмаг %	ЦДЧ dS/m	Хөдөлгөөнт мг/100	
							P ₂ O ₅	K ₂ O
1	Зүсэлт-1 (Агуулахын үрд)	0-15	8.75	0	3.989	0.16	2.04	21.7
		15-30	8.73	0	3.330	0.275	1.79	20.8
2	Зүсэлт-2 (Зогсоолын баруун талд)	0-15	8.63	0	2.013	0.51	1.62	20.4
Тохиромжтой хэмжээ			5.6-8.4	2-10	2-5	0.26-0.77	2-4	10-20

Хөрсний хялбар уусах давсжилт (ЕС): ЕС буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд ЕС нь ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний ЕС-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсийг ЕС1:2.5-ээр нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний үе давхаргад хялбар уусах давсжилт 0.16-0.51 dS/m буюу сулаас дунд зэргийн давсжилттай байна.

Хөрсний хөдөлгөөнт фосфор, калийн хангамж: Хөрсний азот, фосфор, кали (N,P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P₂O₅) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксидаг агууламжаар нь <1мг/100г бол бага хангамжтай, 2-3 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Кали (K) нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K₂O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K₂O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний хөдөлгөөнт фосфорын хангамж 1.62-2.04 мг/кг буюу маш багаас дунд зэрэг хангамжтай байна. Хөдөлгөөнт калийн хангамж 20.4-21.7 мг/кг буюу дунд зэргийн хангамжтай байна.

Хүснэгт 2-10. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Гүн, см	Элс,%	Тоос,%	Шавар,%	Нэршил
Зүсэлт-1 (Агуулахын үрд)	0-15	82	10	8	Элсэрхэг
	15-30	80	10	10	Элсэрхэг
Зүсэлт-1 (Агуулахын үрд)	0-15	80	8	12	Элсэнцэр

Хөрсний механик бүрэлдэхүүн: Хөрсний ус-физик шинж чанарууд ерөнхийдөө хөрсний механик бүрэлдэхүүнээс ихээхэн хамааралтай байдаг бөгөөд механик бүрэлдэхүүн нь 2мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракци нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг байдаг ч ургамалын үндэс чөлөөтэй ургаж хөгжих боломжоор илүү байдаг. Судалгааны үр дүнгээс харахад зонхилон тархсан

хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнд том хэмжээтэй элс болон шавар-тоос фракц давамгайлсан элсэнцэр бүрэлдэхүүнтэй байна.




График 2-4. Хөрсний механик бүрэлдэхүүн

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын талбайн хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг, механик бүрэлдэхүүн агуулахын урд өнгөн үе нь элсэрхэг, зогсоолын хажуу дах элсэнцэр байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь MNS:5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартыг хангаж байна.

Хөрсний хүнд металлын өнөөгийн түвшин: Хортой хүнд металл гэдэгт дараах 11 хүнд металл багтана. Үүнд: Хар тугалга (Pb), кадмий (Cd), хүнцэл (As), хром (Cr), молебден (Mo), цайр (Zn), кобальт (Co), никель (Ni), зэс (Cu), стронций (Sr), ванадий (V) орно. Эдгээрээс As, Cd, Cr, Pb нь онцгой хортой, Co, Cu, Mo, Ni, Sr, V, Zn нь хортой био идэвхт хүнд металлууд гэж үздэг. Онцгой хортой хүнд металлууд нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхүүлэх хүртэл аюултай байдаг. Харин хортой био-идэвхт хүнд металлууд нь хоруу чанарын хувьд онцгой хортой хүнд металлуудаас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу орогномол өвчин үүсгэдэг аюултай. Судалгааны үр дүнгээс харахад онцгой хортой хүнд металлуудаас кадмий (Cd), био идэвхт хүнд металлаас молибден (Mo) маш бага буюу бараг илрээгүй байна. Бусад металлууд стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүнг Хүснэгт 2-11-т тусгав.

Хүснэгт 2-11. Хөрсөн дэх хүнд металлуудын агууламж

Дээжний нэр	Онцгой хортой хүнд металлууд				Био-идэвхт хүнд металлууд						
	As	Cd	Cr	Pb	Co	Cu	Mo	Ni	Sr	V	Zn
Зүсэлт-1 (Агуулахын урд)	<3	<1	22	37	4	28	<1	11	324	51	81
Зүсэлт-2 (Зогсоолын баруун талд)	<3	<1	19	32	5	43.7	<1	10	325	45	69
Хүлцэх агууламж	20	3	150	100	50	100	5	150	800	150	300



График 2-5. Хөрсний хүнд металлын түвшин

2.6.2 Хөндлөнгийн хяналт шинжилгээ

Хөндлөнгийн хяналт шинжилгээг Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага Баялаг Эко ХХК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усан орчин, ургамлан нөмрөг, амьтны аймгийн судалгааг гүйцэтгэсэн ба үр дүнг доорх хэсэгт тусгав.

2.6.2.1 Усан орчин.**Судалгааны арга зүй**


Зураг 2-16. АТОМТЕХ 6130 зөөврийн багаж

Унд ахуйн усанд дээжлэлт хийхдээ АТОМТЕХ 6130 зөөврийн багажийн ашиглан $^{\circ}\text{C}$, pH, DO, TDS, Salt, mS зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлов (Зураг 2-16). Уг багаж нь pH, ууссан хүчилтөрөгч, булингаршил, давсжилт, цахилгаан дамжуулах чанар, температур зэрэг хэд хэдэн үзүүлэлтийг хэмждэг.

Унд ахуйн усанд дээжлэлт хийсэн бөгөөд хэмжилт хийгдэж буй байдлыг Зураг 2-17-т, байршлыг Зураг 2-18-т тус тус тусгав.



Зураг 2-17. Уст цэгт дээжлэлт хийж буй байдал



Зураг 2-18. Усны дээжлэлт хийсэн байршил болон дээжлэлт хийгдэж буй байдал



Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах
Мэйжор дриллинг монгол ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Төслийн талбайн гадаргын усны төлөв байдлын тойм

Ажилчдын үнд ахуйн уснаас 2024 оны 10 сарын 18-ий өдөр дээжлэлт хийсэн ба доорх хэсэгт усны хими, физикийн шинжилгээний мэдээллийг дэлгэрэнгүй тусгалаа.

Усны хими, физикийн шинжилгээ

Үнд ахуйн усны чанар найрлага экологийн өнөөгийн шинж төлөв, бохирдолтыг тодорхойлох зорилгоор сорьц авч амархан хувирамтгай нэгдлүүд болон физик үзүүлэлтүүдийг газар дээр нь “Combo water quality meter” зөөврийн багажаар тодорхойлон, Шинжлэх ухааны академи, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораториор шинжлүүлж, үр дүнг тодорхойлов.

“Combo water quality meter” зөөврийн багаж.

Усны дээж нь pH 8 буюу хүчиллэг, цахилгаан дамжуулах чанар 363 $\mu\text{S}/\text{cm}$ байна. Усны чанарын физик үзүүлэлтүүдийн үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2-12. Усны чанарын газар дээрх хэмжилтийн үр дүн

№	Ажлын жагсаалт	Төвийн шугам/үнд ахуйн ус
1.	Огноо	2024.10.18
2.	Гүн	Төвийн шугам
3.	Температур (°C)	21.6 °C
4.	Усан орчин, pH	8
5.	Цахилгаан дамжуулах чанар, ($\mu\text{S}/\text{cm}$)	363
6.	TDS (Нийт ууссан хатуу бодис) (мг/л)	178
7.	Давсжилт буюу Salinity range	0.19
8.	Усанд ууссан хүчилтөрөгчийн хэмжээ буюу DO	5.7

Шинжлэх ухааны академи, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн

Химийн шинжилгээний дүнгээс үзэхэд гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувд цэнгэг, зөөлөн сул шүлтлэг орчинтой үс байна. Шижилсэн химийн үзүүлэлтүүд нь Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998 стандарт шаардлага хангаж байгаа боловч усны орчин хэмжээ (pH) нь стандарт заасан хэмжээнээс бага зэрэг их байна. Усны дээжүүдийн хими-физик үзүүлэлтүүдийн үр дүнг дараах хүснэгтэд тусгав.

Хүснэгт 2-13. Уст цэгүүдийн физикийн үзүүлэлтүүд

Физик чанар:	Төвийн шугам/үнд ахуйн ус
Тунгалаг:	30
Үнэр:	үгүй
Тунадас:	үгүй
Өнгө:	үгүй
Амт:	***
pH	7.1
EC	370
TDS	185
Исэлдэх чанар	0.8

Хүснэгт 2-14. Уст цэгүүдийн химийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	MNS900:2018	EU	WHO	Төвийн шугам/унд ахуйн ус	
Анион	Cl	350	250	250	20.9
	SO ₄	500	250	250	31
	NO ₂	1	0.5	0.5	0
	NO ₃	50	50	50	16
	CO ₃	-	-	-	0
	HCO ₃	-	-	-	122

Үзүүлэлтүүд	MNS900:2018	EU	WHO	Төвийн шугам/унд ахуйн ус
Катион	NaK	-	-	21.5
	Ca	100	100	41.5
	Mg	30	30	6
	NH ₄	1.5	-	0.5
	Fe ⁺⁺	-	-	0
	Fe ⁺⁺⁺	-	-	0
Ерөнхий хатуулаг, мг-экв/дм ³				2.56
Курловын томьёо				$\text{HCO}_3^- 57 \text{ SO}_4^{2-} 19 \text{ Cl}^- 17$ $\text{Mg}^{2+} 2$ $\text{Ca}^{2+} 59 \text{ Na}^+ + \text{K}^+ 27 \text{ Mg}^{2+} 14$

Хүнд металлын шинжилгээний үр дүн

Хүнд металлын шинжилгээний үр дүнгээс харахад хүлцэх хэмжээнээс даваагүй байгаа тул MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна.

Хүснэгт 2-15. Усан дахь хүнд металлын шинжилгээний үр дүн

Хүнд металл, мг/л	MNS900:2018 Хүлцэх агууламж мг/л	Төвийн шугам/унд ахуйн ус
Ca	100	40.4
Cu	2	<0.005
Fe	0.3	<0.05
Mg	30.0	5.67
Mn	0.1	<0.054
Ag	0.1	<0.00002
Hg	0.001	<0.00005
Na	200.0	12.4
Se	0.04	<0.0013
Pb	0.01	<0.00005
Al	0.5	0.01
As	0.01	0.00087
Zn	5.0	2.039

Усны ерөнхий хими, физик шинж чанарын болон хүнд металлын нарийвчилсан шинжилгээний үр дүнгээс харахад MNS 0900:2018.Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын шаардлагыг хангаж байна.

2.6.2.2 Ургамлан нөмрөг.

Судалгааны аргазүй

Ургамлын аймаг, ургамалжилтын судалгааг өмнө хийгдэж байсан судалгааны ажлууд болон, төслийн өмнөх БОТБУ, БОМТ зэрэг судалгаан дээр үндэслэн боловсруулав.

Ургамалжилтын бичиглэл нь тухайн судалгааны бүс нутгийн ургамлан нөмрөгийн талаар тодорхой мэдээлэл олж авах гол арга юм. Газрын гадарга дээрх ургамлан нөмрөгийн бүрхэц, халцгай газар, хайрга чулуу, хагдны хэмжээг тодорхойлохдоо: Л.Г. Раменскийн 1м²-ийн трансектийн тороор ургамлан нөмрөгийн бүрхэц тодорхойлох уламжлалт аргыг хэрэглэдэг. Энэхүү арга нь ажиглалтын талбай дотор дурын цэгийг сонгон трансектийн торыг ашиглан тодорхойлдог. Торны 10 см² нь торны 1%-тай тэнцэнэ. Тус аргаар тооцоолохдоо торыг эгц дээрээс нь харж, зогсоо байдлаас хөрсний гадаргын бүрхцийг 10 см² болгоноор тоолон ургамлын бүрхэц, халцгай газрын хэмжээ, хад чулууны хэмжээ, хагдны бүрхцийг хувилж нүдэн баримжаагаар гаргаж, өвслөг ургамлын арвийг О.Друдегийн хувиараар, сөөгний арвийг бодгалийг тоолох аргаар, тусгагийн бүрхэцийг нүдэн баримжааны аргаар, өндөр, үзэгдэлзүйн үе шатыг тэмдэглэж ургацын дээжийг 1 м² талбайн

ургамлыг газрын хөрстэй тэнцүүлэн авч, дээжээ хатааж, жигнэн дундажлаж тухайн талбайн ургацыг тодорхойлно.



Зураг 2-19. Ургамлын бичиглэлийн үйл явц

Хүснэгт 2-16. Ургамлын бичиглэл хийсэн бланк

Бичиглэлийн дугаар, нэр:				Байршил, координат, өндөршил:			
Ургамалжлын дэд хэв шинж:				Ургамлан бүрхэц:			
Гадаргуу:				Халцгай газар:			
Ургамлан бүлгэмдэл:				Хэгд:			
Талхагдал:				Хад чулуу:			
№	УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН НЭР	Зүйлийн бүрхэц:	Биомасс, гр	СӨӨГ		АНГИЛАА	
				Урт	Өндөр		
ТАЙЛБАР:							

Дараа нь ургамлын төрөл зүйлийг тодорхойлж, ургамалжилтын бичиглэлд тусгагдсан зүйл тус бүрийн бүрхцийн түвшин болон тохиолдцын давтамжийг Браун-Бланкегийн 5 баллын хэмжээсээр үнэлнэ (Mueller-Dombois Dieter, Ellenberg Heinz, 1974).

Хүснэгт 2-17. Браун-Бланкегийн баллын хэмжээс

Браун-Бланкегийн балл	Бүрхэц
г	<5%; маш цөөн бодгаль
+	<5%; цөөн бодгаль
1	<5%; тодорхой тооны бодгаль
2	5-25 %
3	25-50 %
4	50-75 %
5	75-100 %

Эх сурвалж: (Mueller-Dombois Dieter, Ellenberg Heinz, 1974)

Хүснэгт оруулсны дараа тухайн сонгон авсан ургамалжлын ангилааны дагуу боловсруулалт хийж, флористик ангилааны зарчмаар жишиг хүснэгтийг эгнээний дагуу бичиглэлийн дугаар, баганын дагуу ургамлын зүйлийг жагсаан бичиж, зүйл тус бүрд хамаарах баллыг оруулж, боловсруулалтын хүснэгт хийнэ.



Зураг 2-20. Juice package программ



ArcGIS

Зураг 2-21. ArcGIS программ

Ургамалжилтын ангилаанд JUICE package 7.1 програм (Зураг 2-20) ашиглаж үр дүнг гарган, ургамалжилтын ангилааны мэдээнд үндэслэн ArcMap 10.8 газарзүйн мэдээллийн системийн программ (Зураг 2-21) ашиглан төслийн талбайн ургамалжилтын зургийг хийдэг. Түүнчлэн LANDSAT 8 OLI/TIRS хиймэл дагуулын мэдээнд үндэслэн төлөвлөгдөж буй төмөр замын нормальчилсан ялгааны ургамалжилтын индекс буюу NDVI бодолт, зураглалыг ENVI 4.7 программ ашиглан гүйцэтгэнэ.

Төслийн талбайн ургамлан нөмрөгийн судалгаа

Ургамалын аймаг

Химийн бодисын агуулахын талбай болон түүний ойр орчмын нутагт хийсэн ургамлан нөмрөгийн судалгааны дүнд нийт 10 төрлийн 16 зүйлийн ургамал бүртгэгдсэн байна.

Хүснэгт 2-18. Ургамлын зүйлийн бүрдлийн жагсаалт

№	Зүйлийн шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг
1. Asteraceae				
1.	<i>Artemisia macrocephala</i>	Дэнхэр шарилж	Олон наст өвслөг	Шарилж
2.	<i>Artemisia mongolica</i>	Монгол шарилж	Олон наст өвслөг	Шарилж
3.	<i>Taraxacum officinalis</i>	Эмийн багваахай	Олон наст өвслөг	Алаг өвс
2. Betulaceae				
4.	<i>Betula platyphylla</i>	Хавтаг навчит хус	Олон наст модлог	Модлог
3. Poaceae				
5.	<i>Bromus inermis</i>	Соргүй согоовор	Олон наст өвслөг	Үетэн
6.	<i>Chloris virgata</i>	Саваан булган сүүл	Нэг наст өвслөг	Үетэн
7.	<i>Elymus sibirica</i>	Сибирь цагаан суль	Олон наст өвслөг	Үетэн
4. Amaranthaceae				
8.	<i>Chenopodium acuminatum</i>	Шоргор лууль	Нэг наст өвслөг	Алаг өвс
9.	<i>Chenopodium album</i>	Цагаан лууль	Нэг наст өвслөг	Алаг өвс
5. Brassicaceae				
10.	<i>Descurainia sophia</i>	Софийн борбут	Нэг наст өвслөг	Алаг өвс
6. Fabaceae				
11.	<i>Heteropappus hispidus</i>	Арзгар соргоот	Нэг наст өвслөг	Алаг өвс
7. Plantaginaceae				
12.	<i>Plantago major</i>	Их таван салаа	Олон наст өвслөг	Алаг өвс
8. Salicaceae				
13.	<i>Populus laurifolia</i>	Лавр навчит улиас	Олон наст модлог	Модлог
14.	<i>Populus tremula</i>	Улиангар	Олон наст модлог	Модлог
9. Rosaceae				
15.	<i>Potentilla anserina</i>	Галуун гичгэнэ	Олон наст өвслөг	Алаг өвс
10. Polygonaceae				
16.	<i>Rheum compactum</i>	Нягт гишүүнэ	Олон наст өвслөг	Алаг өвс

Төслийн талбай орчимд Монгол улсын улаан номд орсон болон Монгол орны улаан дансны шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн зүйл бүртгэгдээгүй байна.

Ургамлын зүйлийн амьдралын хэлбэр

Нийт бүртгэгдсэн ургамлын 8 зүйл нь олон наст өвслөг, 6 зүйл нь нэг наст өвслөг, 3 зүйл нь олон наст модлог ургамал бүртгэгдсэн байна. Ургамлын амьдралын хэлбэрийн хувьд олон наст өвслөг ургамлууд давамгайлж байна.



График 2-6. Ургамлын амьдралын хэлбэр

Энэхүү график дээр төслийн талбай орчим бүртгэгдсэн нийт ургамлын 47% нь олон наст өвслөг, 35% нь нэг наст өвслөг, 18% нь олон наст модлог ургамлууд тус тус эзэлж байна.

Ургамлын зүйлийн аж ахуйн бүлэг

Төслийн талбайд бүртгэгдсэн нийт ургамлыг аж ахуйн бүлгээр ангилахад 9 зүйлийн алаг өвс, 3 зүйл нь үетэн, 2 зүйл нь шарилж, 3 зүйл модлог ургамал бүртгэгдсэн байна. Аж ахуйн бүлгийн хувьд алаг өвсний төрлийн ургамлууд зонхилж байгааг харж болно.



График 2-7. Талбай дах ургамлын аж ахуйн бүлэг

Энэхүү график дээр төслийн талбай орчим бүртгэгдсэн нийт ургамлын 53% нь алаг өвс, 18% нь үетэн, 12% нь шарилж, 17% нь модлог ургамлууд тус тус эзэлж байна.


Ургамалжилт

Уг талбайн ерөнхий хэв шинж нь шилмүүст ой, уул хоорондын хотгор гүдгэр төрхтэй бөгөөд уулын хээрийн буюу олон наст өвслөг ургамал давамгайлсан хэв шинжтэй. Хүний хөл хөдөлгөөний улмаас хөл газрын буюу лууль, шарилжийн төрлийн ургамлуудын эзлэх хувь багагүй байна.

Төслийн талбай орчмын ургамлан бүлгэмдлүүдийн хэлбэр:


1. Хялгана-хиаг-алаг өвст бүлгэмдэл
2. Газар тариалангийн талбай
3. Алаг өвс-ботууль-сөөгт бүлгэмдэл
4. Хиаг-алаг өвст бүлгэмдэл
5. Улалж үетэнт бүлгэмдэл
6. Чулуурхаг алаг өвс-ботууль бүлгэмдэл
7. Хялгана-ерхөг-алаг өвст бүлгэмдэл

Ийнхүү ангилсан ба тэдгээрийг дотор нь жижиг нэгжүүдэд хувааж, 20 таниур бүхий ургамалжилтын зураг хийсэн.



Зураг 2-22. Төслийн талбайн ургамалжилтын зураг

Ургамалжилтын ангилааны мэдээнд үндэслэн ArcMap 10.8 газарзүйн мэдээллийн системийн программ ашиглан төслийн талбайн ургамалжилтын зургийг хийв. Түүнчлэн LANDSAT 8 OLI/TIRS хиймэл дагуулын 2023 оны 8-р сарын 12-ны мэдээнд үндэслэн төслийн талбайн нормальчилсан ялгааны ургамалжилтын индекс буюу NDVI-ийг тооцоолсон. Уг зураглалын үр дүнгээс харахад төслийн талбайн ойр орчим нь ургамалгүй газар байна.



Зураг 2-23. Төслийн талбай орчмын NDVI зураг

2.6.2.3 Амьтны аймаг.

Төсөл хэрэгжих талбай, түүний орчмын амьтны аймгийн зүйлийн бүрдэл, өнөөгийн байдлыг тогтоож амьтны аймагт болон амьдрах орчинд төслийн зүгээс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлон үнэлэх, цаашид хэрхэн бууруулах арга замыг боловсруулах нь зүйтэй юм.

Улаанбаатар хот орчмын газар нутаг нь Монгол орны амьтны газарзүйн мужлал (Банников, 1954)–аар Ойт хээр, хээрийн дэд мужийн Монгол Дагуурын тойрогт хамаарна.

Төслийн талбай нь монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол дагуурын тойрогт хамаарна. Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалыг Зураг 2-24–т харуулав.



Зураг 2-24. Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлал

Монгол Дагуурын хээрийн тойрог: Хуурай хээр талын талын амьтад зонхилно. Үлийн цагаан оготно ба хэргэлзий оготно, дагуур огдой, дагуур зурам, монгол чичүүл, цагаан зээр, хотны үен, өмхий хүрнэ, солонго, хярс, үнэг, чоно зонхилно. Улаанбаатар хотод зонхилох амьтны зүйлийн жагсаалтыг Хүснэгт 2-19–д харуулав.

Хүснэгт 2-19. Зонхилох амьтны зүйлийн жагсаалт

Шавжийн анги-Inspect	
Хатуу далавчтан буюу цохны баг	
<i>Coleoptera</i>	
Жийгээ цохны овог	
<i>Carabidae</i>	
1	<i>Taphoxenus laticollis Dej</i>
2	<i>Taphoxenus dauricus Fish</i>
3	<i>Amara fodinoe Mannh</i>
4	<i>Harpalus amlicollis Men</i>
5	<i>Harpalus cervus Duff</i>
Илтсэн сахалт цохны овог	
<i>Scarabaeidae</i>	
1	<i>Gymnopleurus mopsus</i>
2	<i>Scarbius sacer</i>
Арьс идэгч цохны овог	
<i>Dermestidae</i>	
1	<i>Dermestes dimidiatus Stev</i>
2	<i>Dermestes sibiricus Er</i>
Нялсуур цохны овог	
<i>Elateridae</i>	
1	<i>Selatosomus latis F</i>
Мөлгөр цохны овог	
<i>Buprestidae</i>	
1	<i>Sphenoptera canaeiculata Pall</i>
Бугалын цохны овог	
<i>Meloidae</i>	
1	<i>Epicauta megacephala Gebi</i>
2	<i>Epicauta sibirica Pall</i>

Шавжийн анги-Inspect	
3	<i>Mylabris frolovi</i> Germ
4	<i>Mylabris sibirica</i> F-W
Эвэрт цохны овог	
<i>Gerambycidae</i>	
1	<i>Eodorcadion carinatus</i> F
2	<i>Eodorcadion humerale</i> Gebi
Шөвгөр цохны овог	
<i>Currulionidae</i>	
1	<i>Othiorrhynchus cribrosicollis</i> Boh
2	<i>Stephanocleonus oxicius</i> Rtt
Хайрсан далавчтаны баг	
<i>Lepidoptera</i>	
Дэнгийн эрвээхэйн овог	
<i>Pyrallidae</i>	
1	<i>Prorophora albidogilvella</i> Roester
2	<i>Staudingoria steppicola</i> Curadja
Сарьсан далавчтаны баг	
<i>Hymenoptera</i>	
Шувууны анги-Aves	
<i>Tephromyia grisae</i> (Mg)	
Шонхор хэлбэртэн	
<i>Falconiformes</i>	
Харцгайн овог	
<i>Accipitridae</i>	
1	Сохор элээ
Шонхор овог	
<i>Falconidae</i>	
1	Идлэг шонхор
Тагтаа хэлбэртэн	
<i>Columbiformes</i>	
Тагтааны овог	
<i>Columbidae</i>	
1	Хадны тагтаа
Бор шувуу хэлбэртэн	
<i>Passeriformes</i>	
Болжморын овог	
<i>Alaudidae</i>	
1	Шороон алаг болжмор
Харагчны овог	
<i>Motacillidae</i>	
1	Хээрийн шийхнүүхэй
2	Талын шийхнүүхэй
Хээрийн овог	
<i>Corvidae</i>	
1	Хон хэрээ
2	Хар хэрээ
3	Турлиах
4	Алаг шаазгай
5	Жунгаа
Хөөндэйн овог	
<i>Turdidae</i>	
1	Адууч чогчоохой
2	Бүжимч чогчоохой
3	Мяраан чогчоохой
Хөхтний анги-MAMMALIA	
1	Орог зусаг
2	Хэргэлзий оготно
3	Гэрийн хулгана

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн төв хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл нь аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно.

Энэ орчимд шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P. montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа (*C. Livia*), Сохор элээ (*Milvus migrans*), Шаазгай (*Pica pica*), Улаан хошуут (*Pyrhcorax*), Хар хэрээ (*Corvus corone*), Хон хэрээ (*Corvus corax*) зэрэг олон үзэгддэг байна.

Нийслэлд өвөлждөг шувуудыг бүртгэж, тоолох ажлыг Нийслэлийн Байгаль орчны газар болон Монголын шувуу хамгаалах төвөөс нийслэлийн долоон дүүргийн газар нутгийг хамруулан зохион байгуулсан байна. 2016 онд явуулсан тооллогоор 27 зүйлийн 7583 бодгаль шувуу бүртгэсэн бол 2017 онд 31 зүйлийн 9494 бодгаль шувуу тоологджээ.

Нийт ажиглагдсан 31 зүйл шувуудаас 100 болон түүнээс дээш тоогоор бүртгэгдсэн 11 зүйлийн шувууд байна. Эдгээрийн олонх нь буюу дагуур ятуу, хондон ангир хоёроос бусад нь манай хотын төв орчимд жилийн аль ч улиралд тогтмол тохиолддог ба дийлэнх нь хэрээний овгийн шувууд юм. Хотын ногоон бүсэд буюу суурин газраас зайдуу дагуур ятуу, нөмрөг тас, алаг тоншуул зэрэг шувууд илүү олон тоогоор бүртгэгдсэн. Бусад түгээмэл шувуудын тоонд хөхвөр тагтаа 1624, шивэрэнхэт бялзуухай 1211, хар хэрээ 1050, улаан хошуут жунгаа 825, алаг шаазгай 594, хон хэрээ 294 багтаж байна.

2.7 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь 2024 оны БОМТ-ний удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- МКЛ сургалтын төвтэй хамтарч химийн бодис аюулгүй ажиллагаа сургалтыг зохион байгуулсан бөгөөд 9 ажилтан хамруулсан бөгөөд ажилчдад сертификат олгосон.
- Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтантай хамтран 19,517,500 төгрөгийн төсөвтэйгөөр нийт 71 ажилтныг сургалтад хамруулсан.
- Химийн бодисын зөвшөөрлийг 2022.04.04 өдөр сунгаж, 0002148 дугаар зөвшөөрөл авсан.
- Энвайроментал Комплайнц ХХК-р байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2024 (БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН, n.d.) онд хийлгэж, аудитын дүгнэлтэд зааснаар БОМТ-г батлуулан мөрдөж ажиллах, биелэлтийг тайлагнах, агуулахын агаарын чанарын дотоод хяналт хийх, Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөөг Хан-уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээр батлуулсан гэх мэт авч хэрэгжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2024 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг Хүснэгт 2-20-т тусгав.

Хүснэгт 2-20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт
1.	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад үргэлжлүүлэн ХАБЭА сургалт зохион байгуулах	 Зураг 2-25. ХАБЭА сургалтын явц Мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА-гийн сургалтыг зохион байгуулсан.
2.	Жил бүр БОМТ-г батлуулж, биелэлтийн тайланг Нийслэлийн БОУАӨГ-т хүргүүлэх	2024 оны БОМТ тайланг батлуулсан бөгөөд 11-р сарын 01-с өмнө биелэлтийн тайланг цахим нэгдсэн системд оруулсан.



Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах
Мэйжор дриллинг монгол ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ДҮГНЭЛТ

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь Химийн бодисын агуулахын 2024 оны БОМТ-нд тусгагдсан ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- 2024 онд хийж гүйцэтгэсэн ногоон байгууламжийн үргэлжлүүлэн арчилж, тордсон.
- Бүх нийтийн цэвэрлэгээг орчны 50 м зайд цэвэрлэгээ.
- Химийн бодис асгарах, алдагдах үед хэрэглэх саармагжуулах хэрэгслийг бэлэн байлгадаг
- Бүх нийтийн цэвэрлэгээг орчны 50 м зайд цэвэрлэгээ хийхээс гадна хогийн цэгийг цэвэрлэх ажил мөн хэрэгжүүлсэн.
- Химийн бодисын аюултай хог хаягдлыг Цэцүүх трэйд ХХК-аар тээвэрлүүлж, устгуулсаар байна.
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан бүх ажлыг хэрэгжүүлсэн.

<i>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг</i>	<i>Хийх ажлын тоо</i>	<i>Хийсэн ажлын тоо</i>	<i>Биелэлт (хувиар)</i>
<i>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт</i>	9	9	100
<i>Ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт</i>	1	1	100
<i>Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт</i>	4	4	100
<i>Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт</i>	5	5	100
<i>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт</i>	4	4	100
<i>Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт</i>	2	2	100
<i>Нийт</i>	25	25	100

Мэйжор дриллинг монгол ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 25 ажлыг хийж гүйцэтгэн, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр амжилттай ажилласан байна.

Хавсралт 1



“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК

ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

Огноо: 2024 оны 05 сарын 30

Гэрээний дугаар: Т-24/0109

Хүлээн авагч:
“Цэцүүх Трейд” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/, Энхтайваны өргөн чөлөө 64/2 тоот “Цэцүүх” оффис, үйлчилгээний төв

Утас: +976 70179777, +976 70180632

Цахим хаяг: www.tsetsuuh.mn

Регистрийн дугаар: 2066521

Цахим шуудан: info@tsetsuuh.mn

Үүсгэгч:

“Мэйжор Дриллинг Монгол” ХХК

Хаяг: : Мэйжордриллинг Монгол ХХК, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ажилчны гудамж, Шинэст JSC Барилга

Утас: 77119950

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 000176030

Регистрийн дугаар: 2704358

Цахим

шуудан: solongobayar.samdantsoodol@majordrilling.com



БАТЛАВ,
"ЦЭЦҮҮХ ТРЕЙД" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... /Н.БИЛГҮҮН/

БАТЛАВ,

"МЭЙЖОР ДРИЛЛИНГ МОНГОЛ" ХХК
ЗАХИРАЛ



СЭМЮЭЛ ВИЛЛИАМС /

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

2024 оны 05 сарын 30 өдөр

№Т-24/049

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ нь №Ш-24/ тоот "Аюултай хог, хаягдал шилжүүлэх гэрээ"-ний салшгүй хэсэг байна.

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас "Цэцүүх трейд" ХХК /цаашид Тээвэрлэгч гэх/ төлөөлж Үйлдвэрийн нягтлан албан тушаалтай Т. Буяндэлгэр, Нөгөө талаас .. нөгөө талаас ""Мэйжор Дриллинг Монгол" ХХК-г /тээвэрлүүлэгч гэх/ төлөөлж Хүний нөөцийн ажилтан албан албан тушаалтай Самданцоодол овогтой Солонгобаяр бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1,2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1 Энэхүү Гэрээгээр Тээвэрлэгч нь Тээвэрлүүлэгчийн даалгаврын дагууаймаг,сум,багын нутаг дэвсгэрт орших "....." ХХК-с Аюултай хог, хаягдлын дагалдах бичигт заасан аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т тээвэрлэн хүргэх ажлыг энэ Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх, зохих ёсоор хүлээлгэн өгөх, Тээвэрлүүлэгч нь тээврийн хөлсийг төлөх, талууд эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна. Энэхүү Гэрээгээр зохицуулагдаагүй харилцааг №... тоот "Аюултай хог хаягдал шилжүүлэх" гэрээ, Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулна.
- 1.2 Тээвэрлэгч ачаа, барааг тээвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг баримтлана.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Тээвэрлэлтийн гэрээний хугацаа 2024 оны 05 сарын 30 өдрөөс 2025 оны 05 сарын 30 өдөр хүртэл жилийн хугацаатай байна.
- 2.2 Энэ гэрээ хэрэгжиж эхлэх огнооноос эхлэн, гэрээний зүйлүүдийн дагуу хугацаанаас нь өмнө цуцлагдахаас бусад тохиолдолд, дуусгавар болох огноог дуусталх хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 2.3 Гэрээний хугацааг гагцхүү талууд харилцан зөвшилцөж, бичгээр зөвшөөрсөний үндсэн дээр өөрчилнө.

ГУРАВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЗАХИАЛГА

- 3.1 Тээвэрлүүлэгч аюултай хог хаягдлаа тээвэрлүүлэх захиалгаа тээвэрлэгчид албан бичгээр эсвэл info@tsetsuuh.mn мэйл хаягаар өгнө. Тээвэрлүүлэгч нь Захиалга өгөх бүртээ тээвэрлүүлэх аюултай

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 2/6


- хог хаягдал болох хуванцар сав, уут шуудайны хэмжээ, ширхэг, жингийн талаарх мэдээллийг тээвэрлэгчид өгнө.
- 3.2 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн өгсөн аюултай хог хаягдлын мэдээллийг харгалзан үзэж хавсралт №1-д дурдсан тээврийн хэрэгслүүдээсээ сонгож тухайн тээвэрлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 3.3 Тээвэрлүүлэгч захиалгаа өгсөнөөр талууд тээвэрлэлтийн хуваарийг 2 хоногийн дотор харилцан тохиролцож гаргана. Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр тээвэрлэлтийн огноог хуанлийн 7 өдрөөр урагшлуулж, хойшлуулж болно.
- 3.4 Тээвэрлэлтийн хуваарь гарсанаас хойш тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн “.....” ХХК-ээс Аюултай хог, хаягдлын дагалдах бичигт заасан аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т талбай дээр гэрээний 3.3-т заасны дагуу товлосон захиалга өгсөн өдөрт очсон байна.
- 3.5 Тээвэрлэгч тээвэрлүүлэгчийн талбай дээр хүрэлцэн очсоноос хойш ... цагийн дотор тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэлд дагалдах бичигт дурдсан аюултай хог хаягдлаа ачиж өгнө.
- 3.6 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчээс аюултай хог хаягдлыг хүлээн авч тээвэрлүүлэгчийн талбайгаас гарсанаас хойш ... цагийн дотор хүлээн авагчийн Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэж өгнө.

ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Гэрээний талууд бичгээр өөрөөр харилцан тохиролцоогүй бол тээвэрлүүлэгч талаас тээвэрлэгчээр ачаа тээвэрлүүлсэн төлбөрөө цаг тухайд нь гэрээний хавсралт №1-д тусгасан тарифаар тооцож төлнө.
- 4.2 Тээвэрлэлтийн хөлсийг дараахи нөхцөлөөр зохицуулна.
- 4.2.1 Тээвэрлүүлэгч нь аюултай хог хаягдлаа тээвэрлүүлж хүлээлгэн өгсөнөөс хойш ажлын 5 хоногийн дотор тээвэрлэгчийн нэхэмжлэхийн дагуу 100% төлбөрийг төлнө.
- 4.2.2 Төлбөр тооцоог тээвэрлэгчийн Голомт банк, “Цэцүүх трейд”ХХК, 1715132986 тоот дансаар шилжүүлнэ.

ТАВ. ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Тээвэрлэгчээр аюултай хог, хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргүүлэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүрэгтэй.
- 5.2 Аюултай хог, хаягдлыг тусгай зориулалт бүхий “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээ бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг тээвэрлэгчээс шаардах эрхтэй.
- 5.3 Тээвэрлүүлэгч аюултай хог, хаягдлыг тээвэрлэгчид хүлээлгэн өгөхдөө Тэмдэг, тэмдэглэгээтэй зориулалтын саванд савласан, хог хаягдлын дагалдах бичгийн хамт ачиж өгнө.
- 5.4 Хог хаягдлын дагалдах бичгийг үнэн зөв бөглөсөн байх, хэрэв худал зөрүүтэй мэдээлсэнээс аюул, осол гарах, хүлээн авагч хог хаягдлыг хүлээн авахгүй байх нөхцөл байдал үүсвэл хариуцлагыг тээвэрлүүлэгч хүлээнэ.
- 5.5 Тээвэрлүүлэгч буюу Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
- 5.6 Аюултай хог хаягдлыг гэрээнд заасан газарт хүргэж, хүлээлгэн өгөх үед хүлээн авагч нь хог, хаягдлыг хүлээн авсан тухай гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан дагалдах бичгийн 2 дах хувийг тээвэрлэгчээс шаардан авах эрхтэй.
- 5.7 Тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчид аюултай хог, хаягдлын талаарх зохих мэдээлэл, зааварчилгаагаар бүрэн хангах үүрэгтэй.
- 5.8 Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэх үед хог хаягдал нь дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээтэйгээ таарч байгаа эсэхийг хамтран шалгах үүрэгтэй. Хэрэв таарахгүй байвал ачих аюултай хог хаягдлын мэдээллийг үнэн зөв агуулсан дагалдах бичгийг дахин үйлдэж тээвэрлэгчид өгнө.
- 5.9 Аюултай хог, хаягдлыг хамтран шалгасан боловч тухайн үед нуугдмал байдалд байсан химийн бодисын үл зохицол, савны ёроолыг зохих журмын дагуу шавхаагүй байдлыг илрүүлэх боломжгүй нөхцөл байдлаас үүдэж байгаль орчин, хүн, амьтан, тээврийн хэрэгсэл зэрэгт хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 3/6

- 5.10 Аюултай хог, хаягдлыг тээвэрлэгчид зохих журмын хүлээлгэн өгч ачуулсанаар эрсдэл тээвэрлэгчид шилжинэ. Гагцхүү дагалдах бичгийг худал, зөрүүтэй бөглөсөн болон гэрээний 5.9-д заасан нөхцөл байдал үүссэнээс байгаль орчин, хүн, амьтан, эд хөрөнгөд хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.

ЗУРГАА. ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ППИ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэх үүрэгтэй.
- 6.2 Тээвэрлэгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй, хог хаягдлыг тээвэрлэх зориулалт бүхий бүхээгтэй байх ба зохих стандарт нөхцлийг хангасан эвдрэлгүй тээврийн хэрэгслээр аюултай хог, хаягдлыг тээвэрлэх үүрэгтэй.
- 6.3 Тээвэрлэгч нь хог хаягдлын дагалдах бичгийг бүрэн зөв бөглөгдсөн эсэхийг шалгаж хүлээн авна.
- 6.4 Тээвэрлүүлэгчийн аюултай хог хаягдал нь дагалдах бичиг, төрөл, тоо, хэмжээнд үл зохицол үүсвэл уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 6.5 Тээвэрлэгч нь аюултай хог, хаягдлыг тээвэрлэхдээ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэх ба замын хөдөлгөөний хууль, дүрмийг зөрчсөнөөс тээвэрлүүлэгчид болон бусдад учирсан хохирлыг тээвэрлэгч дангаар хариуцна.
- 6.6 Тээвэрлэгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэхтэй холбогдсон бусад зардлыг өөрөө дангаар хариуцна. / бензин, моторын тос, тээврийн хэрэгсэлд шаардлагатай сэлбэг, багаж хэрэгсэл, хоол хүнс/
- 6.7 Тээвэрлэгч аюултай хог, хаягдлыг хүлээн авснаас хойш хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд хог хаягдал алдагдсан, дутсан, гэмтсэн, эвдэрсэн түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хожимдуулсан хариуцлагыг дангаар өөрийн эд хөрөнгөөр хариуцна.
- 6.8 Харин Аюултай хог, хаягдлыг хамтран шалгасан боловч тухайн үед нуугдмал байдалд байсан химийн бодисын үл зохицол, савны ёроолыг зохих журмын дагуу шавхаагүйг илрүүлэх боломжгүй нөхцөл байдлаас үүдэж байгаль орчин, хүн, амьтан, тээврийн хэрэгсэл зэрэгт хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.
- 6.9 Дагалдах бичигт хавсаргасан буюу өөрөө хүлээн авсан баримт бичгийг үрэгдүүлсэн, буруугаар ашигласны хариуцлагыг тээвэрлэгч хүлээнэ.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА


- 7.1 Тээвэрлүүлэгч нь энэ гэрээний 3-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд тээвэрлэгчид төлнө.
- 7.2 Тээвэрлэгч нь гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй буюу хүлээн авагчид аюултай хог, хаягдлыг хүлээлгэн өгөөгүй бол тээвэрлүүлэгчээс түүнд шилжүүлсэн аюултай хог, хаягдлаа эргүүлэн авах, боломжгүй бол шилжүүлсэн төлбөрөө буцаан шаардах эрхтэй.
- 7.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

НАЙМ. БУСАД ЗААЛТ

- 8.1 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2 Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 8.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж Талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.
- 8.4 Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайлх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 4/6

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ҮНИЙН САНАЛ

№	Авто машины нэр төрөл, даац	Авто машины зураг	Хэмжих нэгж	Нэгж үнэ /Төг/
1	Хүнд даац : 25-30 тонн Машины марк: Nord benz, DAP		1км	4 900 төг
2	Бага даац : 1 тонн Машины марк: Bongo Fronter		1км	2 900 төг

Тайлбар:

Дээрх тээвэрлэлтийн хөлсөд НӨАТ орсон үнэ болно.

- НҮБ 2020 оны аргачлал, Монгол улсын химийн бодисын тухай хууль, Монгол улсын хмийн аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой MNS4978:2000 стандарт, аюултай ачаа тээвэрлэх хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр маршрутын дагуу хөдөлмөр аюулгүй ажилагааг ханган тээвэрлэнэ.
- Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгж Аюултай хог хаягдлын савыг зохих журмыг дагуу бүрэн сулласан байх, хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын дагуу заасан шаардлагыг хангасан байвал зохино.



Хуудсыг баталгаажуулсан:


Хуудас 5/6


**“Мэйжор Дриллинг Монгол” ХХК-н АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ
МАРШРУТ БОЛОН ҮНИЙН САНАЛ**

№	Машины марк даац	Нэг удаагийн тээвэрлэлтийн маршрут	Нийт км	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	/тээврийн хэрэгсэл сонгох/ Тээвэрлэлт хийх давтамж: 1удаа	“.....” ХХК-н захиалгын дагуу хаягтай байршлаас аюултай хог хаягдлыг тээвэрлэн /Төв аймаг Сэргэлэн сум 4- зөрлөг/ нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэх.	2 талд нийткм	тө г	 төг
Нийт дүн: төгрөг					т

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:

“Мэйжор Дриллинг Монгол” ХХК-ийн
Хүний нөөцийн ажилтан

 /Солонгобаяр/

Суурин утас: (976) 77119950

Гар утас: 94212040

Регистер: 2704358

УБ гэрчилгээний дугаар: 000176030

Химийн бодис ашиглах, импортлох тусгай
зөвшөөрлийн дугаар: 00025148

Хаяг: Мэйжордриллинг Монгол ХХК,
Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ажилчны
гудамж, Шинэст JSC Барилга

Хог хаягдал үүсэх хаяг: Өвөрхангай
аймаг, Баруун Баян-Улаан сум болон

Өмнөговь аймаг, Номгон сум

Email хаяг:

solongobayar.samdantsoodol@majordrilling.com

Хүлээн авагч талыг төлөөлж:

Цэцүүх Трейд ХХК-ийн

Үйлдвэрийн нягтлан

 / Т. Буяндэлгэр /

Суурин утас: : (976) 70189778

Факс: : (976) 70180632

Гар утас: 99057786

Регистер: 2066521

УБ гэрчилгээний дугаар: 9011026056

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000007

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх

Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: Buyanaa@tsetsuuh.mn

Шуудангийн хаяг: ШХ-1138



Хуудсыг баталгаажуулсан:



Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000176030

2006.02.08

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9019012091

/ Хувийн хэргийн дугаар /

2704358

/ Регистрийн дугаар /

Мэйжордриллинг монгол

Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал
хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тушаал

/ шийдвэрийн нэр /

А-296

/ дугаар /

2002.04.18

/ он, сар, өдөр /

4610

/ код /

Гадаад худалдаа

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

0990

Гэрээгээр өрөмдлөг хийх

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

19.04.23~21.04.23

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

140,100.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган тэгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, чингисийн өргөн чөлөө, Бармаш барилга, Утас1: 70119951, Утас2:
70119952, Факс: 70119950

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын
бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 1 сар 11 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Metz овогтой Matthew John-а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2016.11.29	Н.Цэжиддулам
2	Дахин гэрчилгээ олгов.	2019.01.11	Х.Түвшинтөр
1	овогтой Davies John Ross -а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.04.27	Г.Санжаа
2	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020.09.24	М.Монголжин
5	Үйл ажиллагаа эрхлэх хугацааг хугацаагүй болгов.	2020.11.30	С.Цолмон
6	Мэйжордриллинг монгол оноосон нэр Мэйжор дриллинг монгол болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2022.12.15	С.Мөнхсанчир
7	Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ажилчны гудамж, Шинэст JSC барилга Утас1: 70119951, Утас2: 70119952, Факс: 70119950 хаягийг шинээр бүртгэв.	2022.12.15	С.Мөнхсанчир
8	Williams овогтой Samuel Robert-а Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2022.12.15	С.Мөнхсанчир

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэгт.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчин үй.



* 0 0 0 1 7 6 0 3 0 *

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,
АШИГЛАХ, ХУДАЛДАХ, УСТГАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2022-04-04

Дугаар: 0002148

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: Мэйжордриллинг монгол ГХО ХХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9019012091

Регистрийн дугаар: 2704358

Хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, чингисийн өргөн чөлөө, Бармаш барилга

Утас: 70119952, 70119952

Дараах химийн хортой, аюултай бодис:

Ашиглах

аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрлийг

2022.04.01-2025.12.31

хүртэл хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Хавсралтад дурдсан 62 нэр төрлийн бодис						
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: ---

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга

Э.БАТТУЛГА /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ц.БАТЖАРГАЛ /

**Химийн хорт болон аюултай бодисыг
Ашиглах 0002148 дугаартай
тусгай зөвшөөрлийн хавсралт**

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томъёо	CAS дугаар	Зөвшөөрсөн хэмжээ, тн
1	Өрмийн алхны тос	Hammer oil 150	Highly refined paraffinnic oil>60%	5500-88	3
2	Өрмийн алхны тос	Hammer oil 320	Highly refined paraffinnic oil>60%	5500-88	3
3	Өрмийн штангийн тос	Amc liquid rod grease	CH ₂ -O-C(O)-R1 CH-O-C(O)-R2 CH ₂ -O-C(O)-R3	7641-44	6
4	Өрмийн штангийн тос /өндөр идэвхт/	Amc rod grease xtra tacky	Barium, acetate tallow fatty acid complex hydrocarbon mineral oil (70-80%)	64742-52-5	12
5	Өрмийн хошууны тос	Ep bit lube	Refined Vegetable oil CH ₂ -O-C(O)-R1 CH-O-C(O)-R ₂ CH ₂ -O-C(O)-R ₃	6921-10-3	12
6	Ургамлын гаралтай тастагчийн тос	Amc universal		7639-46	15
7	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	Penetrol xtra		7639-46	2.4
8	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	Torque-free xtra		7177-11	2.4
9	Органик полимер	Austrol	[C ₆ H ₇ O ₂ (OH) ₃ -X(OC ₂ H ₅)X] _n 100% ethylcellulose	9004-57-3	15
10	Шингэн полимер	Amc-liquid pol	Drilling fluid additive	60815	15
11	Сэргээх полимер	Amc-cr-650	Drilling fluid additive, 100%	4902-92	15
12	Полимер, өсдөг	Amc-aus plug	Cross-linked polyacrylamide, 100%	9003-05-8	6
13	Нийлэг ко-полимер	Aus-floc	Co-Polymer	4902-93	2.4
14	Нийлэг ко-полимер	Aus-floc blocks		6089-06	2.3
15	Цэвэрлэгч полимер	Well clean	Sodium carboxymethyl cellulose, 100%	7758-16-9	1.44
16	Полимер, цавуулаг	Amc pac-l	Sodium carboxymethyl cellulose, 100%	9004-32-4	2.3
17	Полимер, цавуулаг	Amc pac-r			9
18	Полимер, цавуулаг	Ezee pac-r			9
19	Өрөмдлөгийн цемент	Gyp-set 15	Calcium sulfate	10034-76-1	8
20	Өрөмдлөгийн цемент	Gyp-set 30	hemihydrate	10034-76-1	6
21	Шингэн цемент	Fr-100I	Naphthalenesulfonic acids	68153-01-5	2.4
22	Цементийн нэмэлт	Amc xxx 10	Calcium chloride 80%	10043-52-4 68131-74-8	1
23	Цементийн нэмэлт	Amc xxx 15	fly ash-low quartz 20%		1.4
24	Өрөмдлөгийн хөөс	Super foam	Anionic surfactants, 60%	7177-08	2.4
25	Өрөмдлөгийн нийлэг хөөс	Aus grip a eco	Polyethylene polypropylene glycol glyceryl ether	9082-00-2	1.6

26	Өрөмдлөгийн нийлэг хөөс	Aus grip b eco	Polymeric diphenylmethane diisocyanate	9016-87-9	0.2
27	Өрөмдлөгийн тэнцвэржүүлэгч	Amc ground stabilizer	Vinyl acetate homopolymer 30-60%	9003-20-7	2.4
28	Өрөмдлөгийн хагарал тогтоогч	Fracseal	Micronised organic cellulose fiber, 100%	9004-34-6	2.6
29	Өрмийн угаалгын шингэн	Amc truck	Detergent blend, 100 %	7639-45	2.4
30	Концентратат цэвэрлэгч бодис	Amc aus det xtra	Nonhazardous ingredients, 60	7732-18-5	2.4
31	Ус ангижруулагч	Soda ash	Sodium carbonate, 99%	497-19-8	3
32	Кальцийн хлорид	Calcium chloride	Calcium chloride, 85%	10043-52-4	3
33	Калийн хлорид	Potassium chloride	Potassium chloride, 99% KCL	7447-40-7	3.150
34	Өрөмдлөгийн ус ангижруулагч	Amc water conditioner	EDTA tetrasodium salt 75%, sodium carbonate 25%	64-02-8 497-19-8	1.440
35	Барийн сульфат	Barite	Barium sulfate	7727-43-7	3.6
36	Ус алдалт тогтоогч	Shur seal	Shredded paper	42071	0.6
37	Филтрекс	Filtrex	Ingredients determined not to be hazardous>90	NA	6
38	Өрмийн шингэн найруулагч	Ausgel	NA	NA	6
39	Супер Поли, Өрөмдлөгийн полимер	Super Poly	Акрилаци кополимер 30-40 %, хөнгөн нефтийн нэрмэл бодис 10-30 %, ус 30-70%	-	6
40	Өрмийн шавар	Super Gel Sinomud CX Ben	Bentonite (organic clay) 60-100 %	1302-78-9	6
41	Өрмийн тос	Rod Grease	--	9003-29-6	6
42	ПЛАГ	Plug	-	9003-004-7	6
43	Өрмийн тос /усан суурьт дрилл люб/	Drill Lube	(C ₆ H ₁₀ O ₅) _n	91050-89-4	6
44	Целлюлоз	CX-Troll	Polysaccharide 60-100 %	9004-34-6	6
45	Анионик полимер	CHP Plus	Акрилат кополимер 90-95 %	25035-69-2	6
46	Ургамлын гаралтай уусдаг тос	SUPERLUBE	Triethanolamine <1, sodium sulfate <5	NA	15
47	Тос	AMC Thread Grease-DRTG	NA	NA	15
48	Ксантан хүнсний өтгөрүүлэгч	Sino mud Poly XCD	Ксантан бохь 60-90 %	11138-66-2	3
49	Биоцид	AMC Biocide G	Tetrakis (hydroxymethyl) phosphonium sulfate <25, ingredients	55566-30-08	3

			determined not to be hazardous >60		
50	Усан суурьтай өрөмдлөгийн шингэнд хэрэглэх зориулалттай силикон суурьтай бүх төрлийн хөөс арилгагч	AUS Defoamer S	-	26-5533	3
51	Цардуул	AMC Aus Dex	Холимог >60	9005-25-8	3
52	Органик полимер	AMC Ezeetrol	Sodium carboxymethyl cellulose (>60%); sodium carbonate (<5%)	-	3
53	Нимбэгийн хүчил	Citric Acid	Citric acid > -96	77-92-9	3
54	Өндөр чанарын занарын урвал саармагжуулах	Sinomud Kla- stab	Полиамин	9046-10-0	3
55	Өрөмдлөгийн шингэний нэгдэл.	AMC Ben Viscosifier.	Bentonite, >94 %	1302-78-9	3
56	Өрөмдлөгийн шингэн нэмэлт	AMC Glute 9 AMC Glute 50	Глутаральдегид 50%, ус 50%	111-30-8 7732-18-5	3
57	Натрийн сульфит	Sodium Sulphite Sodium Sulfate Anhydrous	Sodium Sulphite >95	7757-83-7	3
58	Өрөмдлөгийн нэмэлт шингэн	AMC Quick Seal	Найрлагыг аюулгүй гэж тодорхойлсон, 100 %	62-2620	3
59	Сийл лац	Sinomud Seal	Шааран ноосон эслэг 60-100 %	65996-69-2	3
60	Натрийн бикарбонат	AMC Sodium bicarbonate	Sodium bicarbonate >99	144-55-5	3
61	Цемент түргэн хатаагч, усгүйжүүлэгч нэмэлт	BASF MasterRheobuild 1000NT	Calcium naphthalene sulphonate - formaldehyde condensate (25 - 50%)	37293-74-6	3
62	Магнийн оксид	Magnesium Oxide	Магнийн оксид >65 %, кальцийн оксид 1-3 %, үлдсэн аюулгүй найрлага	-	3



“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Огноо: 2024 оны 05 сарын 30

Гэрээний дугаар: Ш-24/069

Хүлээн авагч:

“Цэцүүх Трейд” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/,
Энхтайваны өргөн чөлөө 64/2 тоот
“Цэцүүх” оффис, үйлчилгээний төв
Утас: +976 70179777, +976 70180632

Цахим хаяг: www.tsetsuuh.mn

Регистрийн дугаар: 2066521

Цахим шуудан: info@tsetsuuh.mn

Үүсгэгч:

“Мэйжор Дриллинг Монгол” ХХК

Хаяг: : Мэйжордриллинг Монгол ХХК,
Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ажилчны
гудамж, Шинэст JSC Барилга

Утас: 77119950

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:
000176030

Регистрийн дугаар: 2704358

Цахим

шуудан: solongobavar.samdantsoodol@majordrilling.com

БАТЛАВ.
“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



БАТЛАВ.
“Мэйжор Дриллинг Монгол” ХХК
ЗАХИРАЛ



/Н.БИЛГҮҮН/

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 05 сарын 30 -ний өдөр
ХОТ

№ Ш-24/044

Улаанбаатар

Ү-

Нэг талаас Цэцүүх трейд ХХК /цаашид “Хүлээн авагч” гэх/ төлөөлж Үйлдвэрийн нягтлан албан тушаалтай Т. Буяндэлгэр, Нөгөө талаас “Мэйжор Дриллинг Монгол” ХХК -г /цаашид “Үүсгэгч” гэх/ төлөөлж Хүний нөөцийн ажилтан албан албан тушаалтай Самданцоодол овогтой Солонгобаяр бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон уусмалаар

C. Соел

Хуудсыг баталгаажуулсан:

Оюун
Хуудас 2/10

цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

- 2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2024 оны 05 сарын 30 өдрөөс 2025 оны 05 сарын 30 өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 3.2. Энэхүү гэрээний №1-д хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдлын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл info@tsetsuuh.mn хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлон.
- 3.4. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.5. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхэгийг гэрээний хавсралт №2-д заасан төлбөр тооцооны тарифын дагуу харгалзуулан тооцож тухайн үед шилжүүлэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ гарна.
- 3.6. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.7. Үүсгэгч нь шилжүүлсэн аюултай хог хаягдлын төлбөрийг хүлээн авагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор Цэцүүх трейд ХХК-ийн Голомт банкны 1715132986 тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу төлнө.
- 3.8. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
- 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
- 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
- 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
- 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 3/10

- 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
- 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
- 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
- 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.
- 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг
- 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.
- 4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
- 4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 4/10

Зургаа. Өмчлөх эрх шилжих

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам


- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
- 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 5/10

- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Ес. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:

“Мэйжор Дриллинг Монгол” ХХК-г
/тээвэрлүүлэгч гэх/ төлөөлж Хүний
нөөцийн ажилтан албан

 С. Солонгобаяр /

Суурин утас: (976) 77119950

Гар утас: 94212040

Регистер: 2704358

УБ гэрчилгээний дугаар: 000176030

Химийн бодис ашиглах, импортлох тусгай
зөвшөөрлийн дугаар: 00025148


Хаяг: Мэйжордриллинг Монгол ХХК,
Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ажилчны
гудамж, Шинэст JSC Барилга

Email хаяг:

solongobayar.samdantsoodol@majordrilling.com

Хүлээн авагч талыг төлөөлж:

Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн нягтлан

 / Т. Буяндэлгэр /

Суурин утас: 70189778

Гар утас: 99057786

Регистер: 2066521

УБ гэрчилгээний дугаар: 9011026056

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001


Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх
Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: Buyanaa@tsetsuuh.mn

Шуудангийн хаяг: ШХ-1138



Хуудсыг баталгаажуулсан:




Хуудас 6/10

“Цэцүүх Трейд” ХХК, “Мэйжор Дриллинг Монгол” ХХК-ийн хооронд
байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх
2024 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн
Ш-24/..... тоот гэрээний Хавсралт № 01

2024-2025 онд “Мэйжор Дриллинг Монгол” ХХК-ИЙ ЖИЛД УСТГУУЛАХ
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

№	Тухайн сав баглаа агуулагдаж бодисын мэдээлэл	Аюултай хог хаягдлын савны төрөл	Жилд үүсэх тоо хэмжээ / ш, кг, тонн /			
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1	Полимер шүүдэл (1тн)		100	100	100	100
2						



Хуудсыг баталгаажуулсан:


Хуудас 7/10

“Цэцүүх Трейд” ХХК, “Мэйжор Дриллинг Монгол” ХХК-ийн хооронд
байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх
2024 оны дугаар сарын -ны өдрийн
Ш-24/..... тоот гэрээний Хавсралт № 02

**ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ**
(тээврийн зардал багтаагүй үнэ болно)


№	Үйлчилгээний төрөл	Хог хаягдлын төрлийн код	Зураг	Хэмжих нэгж	Нэгж үнэ төг
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр 25л, 50л, 60л,	150109		1кг	1150
2	Химийн хуванцар торх 100л	150109		1ш	4800
3	Химийн хуванцар торх 200л	150109		1ш	7900
4	Химийн хуванцар IBC танк 1000л	150109		1ш	26000
5	Полипропилен уут, шуудай, 25кг, 50 кг, 1 тн big bag шуудай/	150109		1кг	1380

Тайлбар. 1. Дээрх үнэд химийн хортой бодис хадгалсан хаягдал хуванцар савыг хадгалах, дахин боловсруулах үйлчилгээний хөлс бөгөөд тээврийн зардал ороогүй болно.

2. Химийн хортой бодис хадгалсан хуванцар савыг хүлээн авагч авахдаа жинлэж авах ба бага хэмжээтэй тохиолдолд тн-ийг килограммд шилжүүлж тооцно.



Хуудсыг баталгаажуулсан:


Хуудас 8/10

ҮҮСГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Үүсгэгч талыг төлөөлж:

“Мэйжор Дриллинг Монгол” ХХК-ийн
Хүний нөөцийн ажилтан

 / Солонгобаяр /

Суурин утас: (976) 77119950

Гар утас: 94212040

Регистер: 2704358

УБ гэрчилгээний дугаар: 000176030

Химийн бодис ашиглах, импортлох тусгай
зөвшөөрлийн дугаар: 00025148

Хаяг: Мэйжордриллинг Монгол ХХК,
Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ажилчны
гудамж, Шинэст JSC Барилга

Email хаяг:

solongobayar.samdantsoodol@majordrilling.com

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Хүлээн авагч талыг төлөөлж:

Цэцүүх Трейд ХХК-ийн

Үйлдвэрийн нягтлан

 / Т. Буяндэлгэр /

Суурин утас: 70189778

Гар утас: 99057786

Регистер: 2066521

УБ гэрчилгээний дугаар: 9011026056


Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000007

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх


Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: Buyanaa@tsetsuuh.mn

Шуудангийн хаяг: ШХ-1138



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 9/10

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ
№

Дагалдах бичгийн дугаар:
/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /

